

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ЗОРИЛТ, АРГА  
ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ТАНИЛЦУУЛГА /2017 оны хагас жилийн байдлаар/**

**Нэг.Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилгонь Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх тус салбарын төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тухайн онд тавьсан зорилт, хүрэх түвшинтэй харьцуулан хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, дараагийн шатны төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

**Хоёр.Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй**

Хяналтад авсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг шинэ Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн 2017 оны эхний хагас жилийн тайланг судлах, Улсын бүртгэл статистикийн ерөнхий газраас гаргасан “Монгол улсын статистикийн эмхэтгэл 2015”, “Хөдөө аж ахуй 2015”, Гааль, татварын ерөнхий газраас гаргасан “Барааны экспорт, импортын статистикийн мэдээлэл 2015” болон тухайн ажлыг хариуцсан албан тушаалтнуудтай уулзаж ярилцах, холбогдох газруудаас тодруулга авах замаар цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэв.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн тухайн онд хэрэгжүүлсэн ажлын бодит үр дүнг мөн оны хагас жилийн хүрэх түвшинтэй харьцуулан биелэлтийг хувиар тодорхойлж үнэлгээг гаргав. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний 2017 оны эхний хагас жилийн үнэлгээний түвшинг тогтоохдоо дараах жишгийг баримталсан болно. Үүнд:

- 2016-2020 онд хэрэгжих бол 30 %,
- 2016-2019 онд хэрэгжих бол 40 %,
- 2016-2018 онд хэрэгжих бол 50 %,
- 2016-2017 онд хэрэгжих бол 70 %

**Гурав.Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**

Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам дангаар болон толгойлон хэрэгжүүлэхээр тусгагдсан 64 зорилтын 160 арга хэмжээг хяналтад авч хэрэгжилтийг ханган ажилласан.

Төлөвлөгдсөн нийт арга хэмжээнээс 2017 оны хагас жилийн байдлаар 6 арга хэмжээ 70 хувь, 68 арга хэмжээ 40 хувь, 55 арга хэмжээ “0” хувийн биелэлттэй байна. Харин 35 арга хэмжээг үнэлэх боломжгүй байна. Тус салбарын хяналтад авсан арга хэмжээнүүдийн хэрэгжилт дунджаар 24.34 хувь байгаа тул 2017 оны хагас жилд хүрвэл зохих түвшинг “хангалттай сайн” буюу 97.4 % биелүүлсэн гэж дүгнэж байна.

**Дөрөв. Дүгнэлт**

1. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд ХХААХҮ-ийн салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилт 2017 оны хагас жилийн байдлаар 24.34 хувьтай дүгнэгдэв.

**Тав. Зөвлөмж**

1. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд аймаг, орон нутгийн талаар тусгайлан оруулсан заалтуудыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдаагүй, 2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төсөв батлагдаагүй байгаа нь хэрэгжилт удаашрах нөхцөл байдал үүсгэж байгаа тул эдгээр ажлыг эрчимжүүлэх талаар тусгайлсан арга хэмжээ зохион байгуулах шаардлагатай.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД  
ТУСГАГДСАН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ЗОРИЛТ,  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН  
/2017 оны хагас жилийн байдлаар/**

№	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт	Арга хэмжээний дугаар	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хүрэх түвшин, Үр дүнгийн үзүүлэлт	Гарсан үр дүн	Яамны үнэлгээ	ЗГХЭГ-ын үнэлгээ	Тайлбар
<b>НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ ОНЦГОЙ БОДЛОГО</b>									
Тэргүүлэх зорилт №1. Эдийн засагт үүссэн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, макро эдийн засгийн тэнцвэрийг хангах, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, түүхий эдийн үнээс хэт хамааралтай байдлыг бууруулж, төлбөрийн тэнцлийн эрсдэлийг багасгах, дунд хугацаанд учирч байгаа өрийн дарамтыг бууруулах, эдийн засгийг дархлаатай болгох, улмаар эдийн засаг дунд хугацаанд тогтвортой тэлэх бодлогыг баримтална.									
1	1.17. Таваас доошгүй жил тасралтгүй үйл ажиллагаа эрхэлж, байнгын ажлын байр шинээр бий болгосон хөнгөн, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ.	2	Чиглэлийн яамд, холбогдох байгууллагууд-тай хамтран уян хатан нөхцөлтэй зээлээр хөнгөн үйлдвэр, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх /Хөн.ҮБХЗГ, ЖДҮХБХЗГ/	2017-2020	Холбогдох хууль тогтоом-жид өөрчлөлт оруулах	Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны хөтөлбөр, “Экспортыг дэмжих, импортыг орлох 888” –ийн хүрээнд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор 2012-2016 онд бүс нутгийн чанартай зээлд ЖДҮХСангийн болон Хөгжлийн банкны эх үүсвэрээс 2154 төсөлд 381,5 тэрбум төгрөгийг олгосон.Эх үүсвэрээр хүнсний үйлдвэрийн 324 төслийг 60752,8 сая төгрөг, хөнгөн үйлдвэрийн 552 төслийг 73759,01 сая төгрөг, газар тариалангийн 173 төслийг 25334,7 сая төгрөг, мал аж ахуйн 283 төслийг 37191,7 сая төгрөг, барилгын материалын үйлдвэрлэлийн 327 төслийг 88805,3 сая төгрөг, зоорины 35 төслийг 13040,0 сая төгрөг, худалдаа үйлчилгээний 229 төслийг 23629,7 сая төгрөг, боловсруулах үйлдвэрийн 28 төслийг 12039,5 сая төгрөг, дахиварын 9 төслийг 1095,0 сая төгрөг, бусад чиглэлийн 171 төслийг 35121,1 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна. Зээлийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж байгаа бөгөөд одоогоор хяналт шалгалтанд 2154 зээлдэгч хамрагдахаас 2033 зээлдэгч буюу нийт зээлдэгчийн 94 хувь нь хамрагдаж зээлийн ашиглалт 95 хувь, 2,5 хувь нь зээлийг хугацаанаас өмнө төлсөн, 2 хувь нь зориулалт бусаар ашигласан байна. Таваас дээш жил үйл ажиллагаа явуулж буй 18223 ААН байна. Эдгээр ААН-д урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлээр дэмжих дэмжлэгийн төрлийг бий болгох зорилгоор сайдын тушаалын төслийг боловсруулж байна. Ноолуурын салбарын эргэлтийн хөрөнгийн зээлийн эх	40		

						үүсвэрийг шийдвэрлүүлэх ХХААХҮЯамны хүсэлтийн дагуу Хөгжлийн банкны 2017-03-16-ны өдрийн 2017/06 дугаар зээлийн хорооны шийдвэрээр 2015-2016 онд ноолуурын эргэлтийн зээлийг дамжуулан олгосон арилжааны банкинд зээлийн бүрэн буцаан төвлөрүүлсэн эх үүсвэрийг Хөгжлийн банкны нөхцлөөр үйлдвэрлэгчдэд жилийн 18% хүүтэй олгох боломжтой болсон. Азийн хөгжлийн банкны Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр 2017 онд ноос, ноолуурын эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 6 аж ахуйн нэгжид 23,6 тэрбум төгрөг, Хөгжлийн банкны эх үүсвэрээс ноолуурын 5 аж ахуйн нэгжид 17,9 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл олгосон.			
2	1.23. “Үндэсний үйлдвэрлэл” хөтөлбөрийг хэрэгжүүлж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.	1	Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд "Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр", "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр" боловсруулж хэрэгжүүлэх  /БТГ, Хөн.ҮБХЗГ, ЖДҮБХЗГ/	2017-2020	Хөтөлбөр батлагдаж, хэрэгжиж эхлэх	-Хөтөлбөрийн төслийг Засгийн газрын 2016-12-14-ний хуралдаанд хэлэлцүүлж 60 дугаар тэмдэглэлээр дэмжсэн. Хөтөлбөрийн төсөлд Засгийн газрын гишүүдийн саналыг тусган, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журамд нийцүүлэн өөрчлөн боловсруулж байна. -Хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн байдалд үндэслэн макро, микро түвшингийн орчны үнэлгээ, шинжилгээ хийж, хөтөлбөрийн зорилго, зорилтыг томьёолж боловсруулсан. - Хөнгөн, хүнсний үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчид, мэргэжлийн судлаач эрдэмтэд, мэргэжлийн холбоод, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөлтэй 22 удаа хэлэлцүүлэг хийж гарсан саналуудыг хөтөлбөрийн төсөлд тусгасан. -Үйлдвэржилт 21:100 хөтөлбөрийн төслийг Сайд, холбогдох газрын дарга нарт 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр танилцуулав. - Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах тухай журмын дагуу хөтөлбөрийн төсөлд 2017-05-12-ний өдрийн 01/1470 албан тоотойр яамдаас ирсэн саналыг тусгаж, ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. -"Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн төслийг 2 хувилбараар боловсруулж, холбогдох судалгааг “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн хүрээнд хийж, хэлэлцүүлгийг 21 аймаг 9 дүүрэгт хийхээр ЖДҮБХЗГ-ын даргын 2017 оны 06 сарын 20 өдрийн 08/1897 тоотойр хүргүүлээд байна.	40		

**ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО**

Тэргүүлэх зорилт №2.1. Макро тэнцвэрийг бататгасан олон тулгуурт дотоодын үйлдвэрлэлд түшиглэсэн, тогтвортой эдийн засгийг бий болгон Монгол Улсын үндэсний нийт орлогыг нэмэгдүүлж, дундаж-дээгүүр орлоготой орнуудын эгнээнд буцаан оруулна.

3	2.1. Монгол Улсын Үйлдвэржилтийн газрын зургийг гаргаж, хүнд аж үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	1	Монгол Улсын Үйлдвэржил-тийн газрын зургийг экосистем, хүн амын нутагшил, суурьшил, түүхий эдийн нөөц, дэд бүтцийн бодлоготой уялдуулан гаргах /БТГ, Хөн.ҮБХЗГ/	2016-2017	Үйлдвэр-жилтийн газрын зураг гарах	Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр"-ийг боловсруулах явцад 21 аймаг дахь хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн байдлын зураглал гаргасан. Энэхүү зураглал дээр үндэслэн шинээр байгуулах болон өргөтгөх үйлдвэрийн байрлал, чиглэлийг түүхий эдийн болон хүний нөөц, дэд бүтцийн бодлоготой уялдуулан боловсруулж, яамдуудын саналыг тусгаж байна	0		
	2.7. Стандартчилал, хэмжил зүйн талаархи хууль тогтоомжийг олон улсын нийтлэг зарчимд нийцүүлэн шинэчилж, “Үндэсний чанарын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.	4	Экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үндэсний стандартыг шинэчлэх хүрээнд олон улсын болон европын стандартуудыг үндэсний болгох, нутагшуулах	2017 - 2020		хяналтад нэмж авах	ҮБгүй		
	2.9. Үйлдвэрлэлд ашиглагддаг уур, ус, дулаан, цахилгааны тарифыг тогтвортой байлгаж, аажмаар бууруулах бодлого баримтална.	1	Үйлдвэрлэлд ашиглагддаг уур, ус, дулаан, цахилгааны тарифыг тогтвортой байлгах, бууруулах замаар бүтээгдэхүүний өртгийг багасгах бодлого хэрэгжүүлэх	2017 - 2020		хяналтад нэмж авах	ҮБгүй		
4	2.10. Малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, тээвэрлэх, боловсруулах	1	Арьс шир, малын гаралтай дайвар бүтээгдэхүүн, ноос, ноолуурыг боловсруулах, зах	2017-2020	Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд	Арьс шир, малын гаралтай дайвар бүтээгдэхүүн, ноос, ноолуурыг боловсруулах, зах зээлд нийлүүлэх нэмүү өртгийн сүлжээг бүрдүүлж, хөрөнгө оруулалтаар дэмжихээр Азийн хөгжлийн банк, Европийн хөгжлийн сэргээн босголтын банкуудын гадны зээл тусламжид	40		

	нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.		зээлд нийлүүлэх нэмүү өртгийн сүлжээг бүрдүүлж, хөрөнгө оруулалтаар дэмжих /Хөн.ҮБХЗГ/		эргэлтийн хөрөнгө, техник технологи шинэчлэх зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгогдох	хамруулахаар ажиллаж, одоогийн байдлаар Азийн хөгжлийн банкны Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр 2017 онд ноос, ноолуурын эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 6 ААН-д 23,6 тэрбум төгрөг, Хөгжлийн банкны эх үүсвэрээс ноолуурын 5 ААН-д 17,9 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл олгож дэмжлэг үзүүлээд байна.				
5	2.15. “Итгэлийн зээл”-ийг олгож, жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй, бичил бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлнэ.	1	“Итгэлийн зээл”-ийг олгож, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх /ЖДҮХБХЗГ, ЖДҮХС/	2017-2020	150 жижиг, дунд үйлдвэр-лэл эрхлэгчийг хамруулах	Жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй, бичил бизнес эрхлэгчдэд “Итгэлийн зээл”-ийг олгох асуудлыг “Сум хөгжүүлэх сан”-ийн зээл олгох журамд өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэхээр санал боловсруулж байна. Итгэлийн зээлийн шугамыг бий болгох асуудлаар Хас, Хаан банк, Инкубаторуудын холбоотой хамтран ажиллах талаар 2017.06.02 өдөр уулзалт зохион байгуулав.	0			
Тэргүүлэх зорилт №2.2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийг хангах зорилгоор “ЭРҮҮЛ ХҮНС-ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” үндэсний хөтөлбөр, “ҮЙЛДВЭРЖИЛТИЙН 21:100” хөтөлбөр, “ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ” хөтөлбөр, “МАХ, СҮҮНИЙ АНХДУГААР АЯН”-ыг шинээр эхлүүлж, “АТРЫН-III АЯН”-ыг үргэлжүүлэн хэрэгжүүлнэ.										
6	2.18. Хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах зорилгоор “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр хангана.	1	Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын мах, сүүний хэрэгцээг тогтвортой хангах, улирлын хамаарлыг бууруулах зорилгоор гарал үүсэл нь баталгаажсан, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан мал, сүүг үйлдвэр, цехэд нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх	2018-2020	-	Засгийн газрын 2016 оны 212 дугаар тогтоолоор “Мах, сүүний анхдугаар аян”-ыг улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэж хэрэгжилтийг зохион байгуулж эхлээд байна. Энэ хүрээнд хүрээнд “MDM”ХХК-ийн боловсруулсан “Монголын хуурай сүү” төслийг дэмжин ажиллаж байна. Мөн Монголын ээдэмцрийн холбооноос боловсруулж ирүүлсэн “Ээдэмцэр” кластер төслийг дэмжиж Хөгжлийн банкинд 2017 оны 5-р сарын 03-ны өдрийн 01/1306 дугаар албан бичиг хүргүүлээд байна. Үүний зэрэгцээгээр Монгол улс, БНПУ-ийн Засгийн газар хоорондын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих Баянхонгор, Өвөрхангай аймгийн Хангайн бүсийн сумдын малчдыг түшиглэн сарлагийн сүү бэлтгэл-үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашигтай бренд, гаргах үйлдвэр байгуулах төслийн баримт бичиг боловсруулж Сангийн яаманд хүргүүлээд байна. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 14 дүгээр тогтоолоор өвөлжилт хүндэрч байгаа орон нутгаас мал, мах бэлтгэлийг нэмэгдүүлэх чиглэлээр аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж нийт 9 үйлдвэр, мах хадгалах зориулалтын зоорь бүхий аж ахуйн нэгжид	40			

			эдийн засгийн механизмыг бий болгох, үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, сүүний хэмжээг нэмэгдүүлэх, мах, сүүний нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах, малчдын орлогыг нэмэгдүүлэх, /Хү.ҮБХЗГ/			зээлийн хүүний хөнгөлөлтийн дэмжлэг үзүүлж, өвөлжилт хүндэрсэн орон нутгаас 12.9 мянган тонн, мөн “Мах” хөтөлбөрийн хүрээнд 2016 онд зээл нь олгогдсон 4 аж ахуйн нэгж 2.9 мянган тонн, нийт 15.8 мянган тонн махыг бэлтгэсэн. 2017 оны 4 дүгээр сараас эхлэн Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын хаврын улирлын хэрэгцээнд тогтоосон үнээр буюу зах зээл дэх махны үнээс 10-30 хувь хямд үнээр хэрэглэгчдэд нийлүүлж эхэлснээр махны үнийг тогтворжуулж, хаврын улиралд махны хомсдол үүсэхгүй байх нөхцлийг бүрдүүлсэн. Одоогийн байдлаар нийт бэлтгэсэн махны 72 хувь буюу 11.3 мянган тонн махыг худалдан борлуулаад байна.			
	2	"Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт"-ыг батлан хэрэгжүүлэх, сурталчлах /Хү.ҮБХЗГ/	2017-2020	Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтын төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх	"Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт боловсруулах" зөвлөх үйлчилгээний ажлын тайланг гүйцэтгэгчээс 2016 оны 12-р сард хүлээн авсан. Зөвлөх үйлчилгээний хүрээнд баримт бичгийн төслийг мал төхөөрөх болон мах боловсруулах үйлдвэрийн төлөөллийг оролцуулан 2 удаагийн хэлэлцүүлэг хийсэн. 2017 оны 5, 6 дугаар сард яамны холбогдох газар, хэлтэс, мах боловсруулах үйлдвэр, аж ахуйн нэгж, нийтийн хоолны үйлдвэрлэл, мах, махан бүтээгдэхүүний худалдаа эрхлэгч нар, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хэлэлцүүлгийг зохион байгуулсан. "Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт"-ын төслийг Засгийн газрын 2017 оны 11-р сарын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтад оруулахаар санал хүргүүлээд байна.	70			
	3	Улаанбаатар хотын баруун, зүүн талд эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан, зориулалтын хөргөлттэй агуулах бүхий мах, махан бүтээгдэхүүний орчин үеийн бөөний худалдааны нэгдсэн төв байгуулахыг бодлогоор дэмжиж, мал төхөөрөх үйлдвэр болон ХАА-н биржийн үйл ажиллагаатай холбох шийдэл гарган ажиллах /БТГ, Хү.ҮБХЗГ/	2019-2020	2019 оноос хэрэгжинэ	"МБҮ Трейд" ХХК хувийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотод махны төрөлжсөн худалдааны зах байгуулах талаар Нийслэлийн Засаг даргад санал гаргасны дагуу Нийслэлийн Хөдөө аж ахуйн газар, "МБҮ Трейд" ХХК-тай мал, махны төрөлжсөн худалдааны төвийг нийслэлийн баруун зах буюу Сонгинохайрхан дүүргийн 32-р хороо, Эмээлтэд 28 га газарт 2017-2018 онд барьж байгуулахад хамтран ажиллах тухай Санамж бичгийг байгуулж, 2017 оны 06-р сарын 06-нд махны төрөлжсөн захын шав тавих ёслолын ажиллагааг зохион байгуулсан.	ХБгүй			

6		4	Сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх замаар бага насны хүүхдийн эрүүл мэндийг дэмжих зорилгоор "Үдийн цай" хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн ЕБС-ийн бага ангийн сурагчдад өдөр бүр өгөх сүү, сүүн бүтээгдэхүүнийн хэмжээг 200 граммд хүргэх /Хү.ҮБХЗГ, ХНХҮЗХ/	2017-2020	ЕБС-ийн 108 мянган хүүхэд хамрагдах	<p>Монгол Улсад хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэр байгуулах ТЭЗҮ боловсруулах мөн үйлдвэр барихад дэмжлэг хүсэх тухай саналыг боловсруулж, Японы олон улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллагад хүсэлт гаргав.</p> <p>Хүн амын эрүүл мэндийг дэмжих, сүүний хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор “Үдийн цай” хөтөлбөрийн Нийслэлийн ЕБС-ийн бага ангийн хүүхдүүдэд “өдөрт нэг аяга сүү” арга хэмжээний талаар БСШУСЯ-ны сургуулийн бага болон өмнөх боловсролын асуудал хариуцсан албан тушаалтнуудтай ажлын уулзалт зохион байгуулсан. Мөн Монголын Хүнсчдийн Холбоотой хамтран сүүний боловсруулах үйлдвэрийн төлөөлөлтэй уулзаж дээрх асуудлаар санал солилцсон. Цаашдаа “Үдийн цай” хөтөлбөрийн хүрээнд Эрүүл мэндийн яам, БСШУСЯ-тай хамтарсан хэлэлцүүлэг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p> <p>БСШУСЯ-ны сайдын 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/225 тушаалаар батлагдсан Ерөнхий боловсролын сургуулийн "Үдийн цай" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мөрдөх журмыг шинэчлэх, "Цэцэрлэг, дотуур байрын хүүхдийн хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэх журам" шинээр боловсруулах ажлын хүрээнд бага ангийн сурагчдад өгөх сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээ, хагас боловсруулсан мах махан бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх тал дээр санал тусган ажиллаж байна.</p>	40		
7	2.19. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн экспортлох боломжийг бүрдүүлнэ.  /Хү.ҮБХЗГ/	1	Ургамлын гаралтай хүнсийг экспортлох үеийн ургамлын хорио цээрийн шаардлагын тухай протоколыг импортлогч оронтой байгуулах, экспортлох боломжийг бүрдүүлэх	2017-2019	БНХАУ-д гурил экспорт-лох үеийн ургамлын хорио цээрийн шаардла-гын тухай протокол-лыг тохирол-цох	<p>Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн 2017 оны 3-р сарын хурлаар улаанбуудайн гурил экспортлох асуудлыг хэлэлцүүлж, 15.0 мян.тн гурил экспортлох зөвлөмжийг ирүүлсний дагуу ХХААХҮЯ-аас 2017 онд улаанбуудайн гурил экспортлох сонгон шалгаруулалтыг зарласан. Сонгон шалгаруулалтад 11 гурил үйлдвэрлэгч аж ахуйн нэгж оролцож, нийт 77.0 мян.тн гурил экспортлох тухай хүсэлтийг ирүүлсэн байна.</p> <p>Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад гурил экспортлох асуудлаар эрсдлийн хянан магадлагаа хийхтэй холбогдсон асуулгад тус яамны үйл ажиллагаатай холбоотой хэсэгт хариулан МХЕГ-т хүргүүлсэн ба асуулга болон “Монгол Улсаас БНХАУ-д улаанбуудай, хөх тарианы гурил экспортлох үеийн ургамлын хорио цээрийн шаардлагын тухай Протокол”-ын төслийг БНХАУ-ын талд хүргүүлсэн.</p>	40		

						2017 оны 7, 8-р саруудад БНХАУ-д зохион байгуулагдах Хүнсний бүтээгдэхүүний экспорт, импортын аюулгүй байдлын хамтын ажиллагааны Дэд сайд нарын түвшингийн уулзалт болон газрын дарга нарын түвшингийн уулзалтын үеэр Монгол Улсаас БНХАУ-д улаанбуудайн гурил экспортлох асуудлыг хэлэлцэж, протоколыг байгуулах тухай саналыг боловсруулж, танилцуулгын хамт холбогдох газарт хүргүүлсэн. Гурил экспортлох хүсэлтэй гурилын үйлдвэрүүдэд БНХАУ-ын талаас тавих шаардлагын талаар зөвлөгөө өгөх зорилгоор МХЕГ-тай хамтарсан ажлын баг гаргах, үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай танилцаж, газар дээр нь зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулахаар бэлтгэж байна.			
		2	Монгол малын махны физик, химийн үзүүлэлтийн онцлог, давуу талыг шинжлэн судалж тодорхойлон, олон улсын итгэмжлэгдсэн лабораториор баталгаажуулж, махны экспортыг тогтвортой, урт хугацаанд төлөвлөн тодорхойлох, зах зээлийг өргөтгөх, шинэ зах зээлийг нээх	2017-2020	Махны онцлог давуу талыг тогтоох судалгаа хийгдэх	Махны онцлог давуу талыг тогтоох судалгаа хийлгэх, махны экспортыг тогтвортой, урт хугацаанд төлөвлөн тодорхойлох, зах зээлийг өргөтгөх, шинэ зах зээлийг нээх судалгааны ажлыг Азийн хөгжлийн банкны “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн нэмэлт санхүүжилт”-ийн төслийн хүрээнд хийхээр ажлын даалгаврын төслийг боловсруулан хүргүүлээд байна.	0		
8	2.20. Органик болон зохицуулах үйлчилгээтэй хүнсний эрх зүйн орчинг бүрдүүлж, энэ чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх санхүү, хөрөнгө оруулалт, татварын бодлогыг хэрэгжүүлнэ.	1	“Баяжуулсан хүнсний” тухай болон “Зохицуулах үйлчилгээтэй хүнсний” тухай хуулийн төслийг хүн амын хооллолтын хэв маяг, олон улсын чиг хандлагад нийцүүлэн боловсруулах  /БТГ/	2017-2019	Шаардлагатай судалгаа, тооцоог хийх, Баяжуулсан хүнсний тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх	Баяжуулсан хүнсний тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулах ажлын хэсгийг ХХААХҮ-ийн сайдын 2016 оны А-71 дүгээр тушаалаар байгуулсан. Баяжуулсан хүнсний тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг УИХ-ын гишүүн Ц.Гарамжав, А.Ундраа, Б.Батзориг нар санаачлан боловсруулж 2016 оны 12-р сарын 28-нд УИХ-д өргөн мэдүүлсэн. УИХ-ын 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар уг хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэхийг хэлэлцэж дэмжсэн. БОХХАА-н Байнгын хорооны тогтоолоор хуулийн төслийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны холбогдох шатны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Зохицуулах үйлчилгээтэй хүнсний тухай хуулийн төсөл боловсруулах үндэслэл шаардлагыг тодорхойлохтой холбогдуулан баримтын судалгаа хийж байна.	40		



		2	Органик хүнсний тухай хуульд заасан бүртгэл, баталгаажуулалттай холбоотой журам, аргачлал боловсруулж, батлан мөрдүүлэх /Хү.ҮБХЗГ/	2016-2020	Органик хүнсний үйлдвэрлэлд ашиглахыг зөвшөөр-сөн бодисын каталоги хэвлүүлэх	<p>1. НҮБ-ын ХХААБ-ын санхүүжилтээр “Органик хөдөө аж ахуйн гарын авлага”, “Органик хүнс үйлдвэрлэлд тавигдах шаардлагууд” номыг тус бүр 500 хувь, Органик хүнсний тухай хуулийн англи, монгол хэл дээрх гарын авлага, хуулийн тухай 5 төрлийн зурагт хуудсыг тус бүр 2000 хувийг хэвлүүлж, олон нийтэд түгээв.</p> <p>2. Органик үйлдвэрлэлд хэрэглэх бодисын жагсаалтын төслийг салбар чиглэл бүрээр боловсруулан, нийт давхардсан тоогоор 5 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, хүнсний үйлдвэрийн технологичид, судалгааны байгууллагын төлөөллийн саналыг тусгав. Мөн НҮБ-ын ХХААБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, Их Британи улсын Элчин Сайдын яаманд хандан зөвшөөрөгдөх бодисын жагсаалтад орсон бодисын хэрэглэх заавар, физик, хими шинж чанар, худалдан авах эх үүсвэрийн талаарх мэдээллийг багтаасан каталоги гаргах, энэ чиглэлийн эксперт урьж ажилуулахад санхүүгийн туслалцаа үзүүлэх хүсэлтийг тавьсан.</p> <p>3. Органик хүнсний тухай хуулийн танилцуулгыг хийх зорилгоор Төв, орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагын ургамал хамгаалал, хорио цээрийн хяналтын улсын байцаагчид, таримал ургамлын үр хорио цээрийн хяналтын улсын байцаагч нарт Органик газар тариалан эрхлэхэд баримтлах журмын төсөл болон Органик газар тариалангийн үйлдвэрлэлд хэрэглэхийг зөвшөөрсөн хөрсний үржил шим, бүтцийг сайжруулах, ургамал хамгааллын бодис ба ургамлын өсөлт идэвхижүүлэгч бодисын жагсаалтын төслийг тус тус хэлэлцүүлэн саналыг тусгав. Мөн Замын-Үүд, Гашуун сухайт, Дорнод, Хөвсгөл, Ховд аймгийн хилийн мэргэжлийн хяналтын байцаагч нарт зориулан Органик хүнсний тухай хуулийн хэрэгжилтийг хангах болон дагалдаж гарах журам, аргачлалын талаар цахим сургалтыг зохион байгуулав.</p> <p>4. "Органик хүнсний бүртгэл, хяналт, удирдлагын мэдээллийн сангийн бүтэц, архитектур, програм хангамж, тоног төхөөрөмжид тавигдах шаардлагыг тодорхойлох" зөвлөх үйлчилгээ тендерийн холбогдох бэлтгэл ажлыг ханган, зөвлөх үйлчилгээ үзүүлэх сонирхлоо илэрхийлсэн зөвлөхүүдийн материалыг хүлээж аваад байна.</p>	40		
--	--	---	--	-----------	--	---	----	--	--

9	2.21. Аймаг, нийслэл, сум, суурин газруудын хэрэгцээнд тохирсон орчин үеийн дэвшилтэт технологи бүхий бага, дунд оврын хүнсний боловсруулах жишиг загвар үйлдвэрийг байгуулахыг дэмжинэ.	1	Сүүний нөөц ашиглалтыг сайжруулж, үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор орон нутагт сүү, сүүн бүтээгдэхүүний бага, дунд оврын загвар үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэх /Хү.ҮБХЗГ/	2017-2020	Загвар үйлдвэр-ийн ТЭЗҮ-ийг боловсруулах	<p>Аймаг, орон нутгийн сүүний нөөц ашиглалтыг сайжруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор ХХААХҮЯ-ны ТНБД-ын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг “Монголын Хуурай сүү” корпораци болон “Монголын эдэмцрийн холбоо”-оос ирүүлсэн төслийг судлан, холбогдох тооцоо, судалгааг хамтран хийж байна.</p> <p>- Мах, сүүний анхдугаар аяны хүрээнд орон нутгийн сүүний нөөцөд тулгуурлан байгуулах хуурай сүүний бага, дунд оврын үйлдвэрийн тоног төхөөрөмжийг танилцуулах практик сургалт, хэлэлцүүлгийг “MDM” ХХК-тай хамтран 2017 оны 2 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан. Сургалтад Говь-Алтай, Баянхонгор, Архангай, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод аймгаас болон Улаанбаатар хотоос сүү үйлдвэрлэгчид, фермерүүд, хоршоологчид, сүүний салбарын мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөл нийт 100 гаруй хүн оролцож, санал, мэдээлэл солилцов.</p> <p>- “MDM” ХХК-ийн боловсруулсан “Монголын хуурай сүү” төслийг дэмжиж, санхүүжилтын эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр Хөгжлийн банкинд 2017 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 01/730 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Тус төслийн хүрээнд эхний ээлжийн тоног төхөөрөмжүүд 2017 оны 6 дугаар сард багтан орж ирэх тооцоотой байна.</p>	40		
		2	Жимс, жимсгэнэ, чацаргана, ногоогоор эрүүл мэндийг дэмжих /диабет, нүүрс усны өөрчлөлттэй хүмүүст зориулсан/-д чиглэсэн ундаа, шүүс боловсруулах шинэ технологи бүхий загвар үйлдвэр байгуулах ТЭЗҮ-ийг хийх /Хү.ҮБХЗГ, ЖДҮХС/	2018		<p>Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасан “Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр”-т тусгуулахаар санал өгч, салбарын өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээ хийсэн.</p> <p>Азийн хөгжлийн банкны “ХАА, хөдөөгийн хөгжил” төслийн нэмэлт санхүүжилтэд ТЭЗҮ боловсруулах санал өгсөн.</p> <p>Эрүүл мэндэд чиглэсэн ундаа, шүүсний боловсруулах шинэ технологи бүхий энэхүү загвар үйлдвэр нь байгальд ээлтэй, хаягдалгүй, хэмнэлттэй байх зарчимд суурилсан, хүрээлэн буй орчныг хамгаалахад чиглэгдсэн байна. Үйлдвэрийн үйл ажиллагааны хүрээнд жимсний болон үрийн тос, капсул, малын тэжээл үйлдвэрлэх зэрэг кластераар хөгжүүлж, тариалалт, хураалт, хадгалалт, боловсруулалт, борлуулалтын нэгдсэн өртгийн сүлжээ үүсгэн, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх боломжтой.</p>	40		

10	2.22. Хүнсний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим санг бий болгоно.	1	Хүнсний болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Органик хүнсний тухай хуулиудад заасан журмын дагуу бүртгэл мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, стратегийн болон гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний тэнцэл, шим тэжээлийн хангамжийг тооцоолох аргачлал, программ боловсруулж нэгдсэн санд холбож, ашиглах /Хү.ҮБХЗГ/	2016-2020	Мэдээллийн нэгдсэн сангийн бүтэц, программыг боловсруулах	“Стратегийн болон гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нэгдсэн сангийн бүтэц, загвар, Монгол улсын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний тэнцлийг тооцох программ хангамжид тавигдах шаардлагыг боловсруулах”, “Органик хүнсний бүртгэл, хяналт, удирдлагын мэдээллийн сангийн бүтэц, архитектур, програм хангамж, тоног төхөөрөмжид тавигдах шаардлагыг тодорхойлох” зорилгоор №СХОХ/17/01/01 дугаартай зөвлөх үйлчилгээний тендерийг зарлаж 5-р сарын 29-ны өдөр зөвлөх үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хуулийн этгээдийн материалыг хүлээн авч цаашид хийх ажлыг төлөвлөн ажиллаж байна.	0		
11	2.23. Иргэдийн эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж, хүнсний бүтээгдэхүүний бэлтгэл, боловсруулалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтын тогтолцоог бий болгож, хүнсний аюулгүй байдлыг сайжруулна.	1	“Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн” хөтөлбөр хэрэгжүүлэх  /БТГ, Хүнсний /ҮБХЗГ/	2017-2020	Хөтөлбөр батлуулах, хэрэгжиж эхлэх	-“Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөр 2009-2016 онд хэрэгжин дуусч байгаатай холбогдуулан “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” зорилтын дор хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой үндэсний хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсгийг ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А-159 дүгээр тушаалаар байгуулж, хөтөлбөрийн төсөл боловсруулах үндэслэл шаардлагыг тогтоох нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, хөтөлбөрийн төслийн эхний хувилбарыг боловсруулав.	0		
		2	Хүнсний боловсруулах үйлдвэрт эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг хэвшүүлэх зааврыг батлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах /Хү.ҮБХЗГ/	2016-2020	Зохистой дадлыг нэвтрүүлэх зааврыг батлах	Хөдөө аж ахуй, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх зааврын төслийг эхний байдлаар боловсруулсан. Хөдөө аж ахуйн салбарт, ялангуяа уламжлалт бэлчээрийн мал аж ахуйн салбарт зохистой дадлыг нэвтрүүлэх зааврыг боловсруулахад нэмэлт судалгаа шаардаж байгаа бөгөөд зааврын төслийг энэ оны 3 дугаар улиралд батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.	0		
		3	Нийтийн хоол үйлчилгээнд эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлж,	2017-2020	Эрх зүйн орчин бүрдэж, томоохон сүлжээ рестора-	Нийтийн хоолны газруудыг зэрэглэх тогтоох арга хэмжээний хүрээнд олон улсын хууль эрх зүйн баримт бичиг, туршлагыг судалж, Хүнсний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах үндэслэл шаардлага, Үндэсний стандартыг шинэчлэн боловсруулж, хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.	0		

		зэрэглэл тогтоох  /Хү.ҮБХЗГ, ХНХҮЗХ/		нуудад зэрэглэл тогтоох үйл ажилла-гааг гуршил-гаар явуулах	<p>2017 оны 3-р сард олон улсын сертификаттай “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд эрүүл ахуйн зохистой дадал нэвтрүүлж, НАССР тогтолцоог нэвтрүүлэх нь” сургалтыг Мастер тогоочдыг хамруулан зохион байгуулав.</p> <p>Зүүн болон Төв, Хангайн бүсийн аймгуудын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын ажилтнуудад зориулан Сүхбаатар болон Дархан-Уул аймгуудад 2017 оны 4-5-р сард “Үндэсний болон орон нутгийн онцлогтой хоол, ундааг хөгжүүлэх нь” сэдвээр сургалт зохион байгуулж, салбарын бодлого, олон улсын хөгжлийн хандлага, ЭАЗД хэвшүүлэх, НАССР тогтолцооны талаар сургалтад хамрагдсан 420 гаруй хүнд хичээл зааж, мэдээлэл хүргэв.</p> <p>Мөн цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хүнсний хангамж, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл үйлчилгээг сайжруулах чиглэлээр “Тендерийн үнэлгээний хороо байгуулах тухай” Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А-15 дугаар тушаалаар батлуулж, ажлын хэсэг “Цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хүнсний хангамж, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний зөвлөх үйлчилгээний өнөөгийн байдлын бүсчилсэн судалгаа” ТШ/2017/04/14/5.10 дугаартай 18 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичгийг боловсруулан батлуулж, ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу тендерийн шалгаруулалтыг зохион байгуулсан. Тендерийн сонгон шалгаруулалтаар Тендерийн үнэлгээний хорооны үнэлгээ, зөвлөмжөөр “Хамгийн сайн” үнэлэгдсэн Хоолзүй шим судлалын Монголын нийгэмлэг ТББ шалгарч, зөвлөмжийн дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн “Гэрээ байгуулах эрх олгох, арга хэмжээ санхүүжүүлэх тухай” А-190 дугаар тушаал гарч холбогдох гэрээ хэлэлцээрийн түвшинд ажиллаж байна.</p>			
	4	"Сав баглаа боодол" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх /БТГ, Хү.ҮБХЗГ, Хөн.ҮБХЗГ/	2017-2020	Хөтөлбөрийн хэрэгжилтийг 10 хувьд хүргэх	<p>“Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах журмыг батлах эрхийг Засгийн газрын 2017 оны “Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай” 27 дугаар тогтоолоор хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд олгосны дагуу ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А/54 дүгээр “Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай” тушаал гаргав.</p>	0		

					<p>Мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний болон уг төлөвлөгөөг батлах тухай хамтарсан тушаалын төсөл боловсруулан хамтран батлах Эрүүл мэндийн болон Сангийн сайд нарт хүргүүлээд байна.</p> <p>2017 оны 6-р сард зохион байгуулагдсан ХХААХҮЯ-ны “Нээлттэй хаалганы өдөрлөг” арга хэмжээний үеэр хүнсний зориулалтын бус хуванцар савны хэрэглээг бууруулах талаар сурталчилгааны материал 1000 хувь хэвлүүлж, хэрэглэгчдэд тарааж сурталчлав.</p> <p>Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх зорилтот төслүүдэд санхүүжилт татах зорилгоор Монгол улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрууд, олон улсын байгууллагуудыг оролцуулсан хандивчлагчдын зөвлөлдөх уулзалтыг 2017 оны 9-р сард зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.</p>				
		5	Хүн амын хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх мэдээлэл, сурталчилгаа болон хүнсний үйлдвэрлэгчид, судалгаа шинжилгээний ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх	2017-2020	Жил бүр 8-аас доошгүй сургалт, хэлэлцүү-лэг зохион байгуулж, 300-аас доошгүй хүн хамруулах	<p>1. Хүн амын хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх чиглэлээр:</p> <p>- Дэлхийн хүнсний өдрийг тохиолдуулан жил бүрийн 10-р сарын 16-нд “Хүнсний аюулгүй байдал” эрдэм шинжилгээний бага хурлыг уламжлал болгон зохион байгуулах удирдамжийг ХХААХҮ-ийн сайдын 2017 оны 4-р сарын 20-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар, удирдамжийн дагуу бага хурал зохион байгуулах ажлын хэсгийг ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А-197 дугаар тушаалаар тус тус байгуулсан. “Хүнсний аюулгүй байдал - 2017” бага хурлыг хүнсний хангамж, үйлдвэрлэл, хүртээмж гэсэн сэдвээр зохион байгуулахаар шийдвэрлэн ажиллаж байна.</p> <p>2. Хүнсний салбарт ажиллагсдын чадавхийг бэхжүүлэх талаар:</p> <p>Тайланд улсын Бангкок хотод зохион байгуулсан “Хүнсний аюулгүй байдал, шим тэжээл” сэдэвт 9 хүнийг, БНХАУ-ын Худалдааны яам, Хүнс, исгэлтийн үйлдвэрлэлийн ЭШХ-ээс зохион байгуулсан Хүнсний аюулгүй байдлын менежмент сэдэвт 6 удаагийн сургалтад 60 хүнийг, “Торгоны зам дагуух улс орны согтууруулах ундааны үйлдвэрлэлийн менежмент” сэдэвт сургалтад 8 хүнийг, БНСУ-ын Сөүл хотноо зохион байгуулсан “Хүнсний аюулгүй байдлын менежмент” сэдэвт семинарт 2 мэргэжилтнийг, БНТУ-ын ОУ-ын хамтын ажиллагааны ТИКА байгууллагатай хамтран</p>	40		

					зохион байгуулсан “Мал нядалгааны халал стандартыг нэвтрүүлэх нь” сэдэвт 2 үе шаттай сургалтад 60 хүнийг, тогооч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтад 300 хүнийг хамруулж чадавхийг бэхжүүлсэн.				
		6	Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх суурь судалгаа хийх, журам боловсруулах, сургалт зохион байгуулах  /Хү.ҮБХЗГ/	2017-2018	Журмын төсөл боловсруулж, тооцоо судалгаа хийх	<p>- Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дугаар заалтыг хэрэгжүүлэхээр “Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг боловсруулах ажлын хэсгийг байгуулахаар 01/269 албан тоотоор холбогдох төрийн болон төрийн бус байгууллагаас саналыг авч ажлын хэсгийг байгуулахад бэлэн болсон байна. Тус журмын төслийн эхний хувилбарыг боловсруулав.</p> <p>- ХХААХҮ-ийн сайд аймгийн Засаг дарга нартай байгуулах 2017 оны үр дүнгийн гэрээнд тухайн орон нутгийн хэмжээндээ стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах талаар аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулах мөн хүнсний үйлдвэр, цехийн хүчин чадал, түүний ашиглалт болон хөдөө аж ахуйн гаралтай хүнсний түүхий эдийн нөөцийн суурь судалгааг сум тус бүрээр гаргах тухай заалтыг тусгасан. Үүний дагуу аймаг орон нутгийн хэмжээнд хүнсний үйлдвэр, цехийн хүчин чадал, түүний ашиглалт болон хөдөө аж ахуйн гаралтай хүнсний түүхий эдийн нөөцийн судалгааг гаргасныг нэгтгэн танилцуулахаар ажиллаж байна.</p>	0		
		7	Согтууруулах ундааны үйлдвэрлэл, импортын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог шинэчилж, тусгай зөвшөөрлийн хугацаа, нөхцөл, шаардлагад хяналт тавих	2017-2020	Эрх зүйн актыг олон улсын жишигт нийцүүлэх судалгаа хийж, туршлага судлах	<p>ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2017 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А-19 дүгээр тушаалаар “Согтууруулах ундаа, тамхи импортлох тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмын төсөл болон Согтууруулах ундааны үйлдвэрийн төсөл сонгон шалгаруулах, үйлдвэрлэлд хяналт тавих, Хүнсний болон техникийн зориулалтаар ашиглах спиртийн хуваарилалт, олголт, зарцуулалт, түүнд хяналт тавих журмыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг” байгуулан журмын төсөл, Засгийн газрын шийдвэрийн төсөл, танилцуулгыг боловсруулж, ажлын хэсгийн гишүүдээс санал авч байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 2-р сарын 01-ний өдрийн 46 дугаар тогтоолоор даалгасны дагуу МХЕГ, ТЕГ-тай хамтран улсын хэмжээнд согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн</p>	40		

						<p>нэгжүүдийн үйл ажиллагаанд холбогдох хуульд заасан нийтлэг эрх, үүргийн хүрээнд тусгай зөвшөөрлийн хугацаа, нөхцөл, шаардлагад хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, өмнөх онуудад үйлдсэн албан шаардлага, өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах, эрсдлийн үнэлгээнд тулгуурлан эрх бүхий албан тушаалтан, улсын байцаагчийн дүгнэлт, санал гаргах, хяналт шалгалтын дүнг Засгийн газарт танилцуулахаар удирдамж боловсруулан баталж, ажлын хэсгүүдийг томилон, улсын хэмжээнд хяналт шалгалт хийж байна.</p> <p>Хяналт, шалгалтад Ховд, Дорнод, Өмнөговь, Увс, Баян-Өлгий, Дундговь, Хөвсгөл, Архангай, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Булган, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Төв, Улаанбаатар зэрэг аймаг, хотын согтууруулах ундааны үйлдвэрүүдийг хамруулсан. Хяналт шалгалтын дүнг энэ оны 6 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулж, холбогдох шийдвэр гаргуулна.</p>			
12	2.24. Дотоодын хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, тахиа, гахай, зөгий, загасны аж ахуй зэрэг дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн, бүтээгдэхүүний нийлүүлэлт, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1	Мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, шинэ технологи нэвтрүүлэх, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах зорилгоор шинэ шугам суурилуулах, үйлдвэрлэл өргөтгөхөд зээлийн дэмжлэг үзүүлэх  /Хүнсний /ҮБХЗГ, ЖДҮХС/	2017-2020	Мал, амьтны гаралтай хүнсний 1-2 нэр төрлийн бүтээгдэхүүн шинээр бий болох	<p>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, НҮБ-ын ХХААБ, ХААИС-ийн Мал Аж Ахуй Биотехнологийн сургуулийн хамтран хэрэгжүүлсэн “Загас, загасан бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд цөөрмийн аж ахуйг Монголд хөгжүүлэх” ТСР/MON/3501 төслийн хүрээнд 200.000 ширхэг загас үржүүлэх хүчин чадалтай “Загас үржүүлгийн лаборатори” ашиглалтад орж, 2017 оны 5-р сарын 29-нд нээлтийн ажиллагаа хийсэн.</p> <p>Төслийн санхүүжилтээр 75 мянган ам.долларын өртөг бүхий загас үржүүлгийн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. Энэхүү лаборатори байгуулагдсанаар Загасны аж ахуйн салбарт мэргэжилтэн бэлтгэх, сургалтын орчинг бий болгох, нэн ховор, ховор зүйл загасыг зохиомол аргаар үржүүлэх, байгалийн нөхөн сэргээлт хийх, загасны аж ахуй эрхлэгч нарт жарамгай, жараахай нийлүүлэх, зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, судалгааны ажлыг орчин үеийн шинжлэх ухаан технологийн дэвшлийн түвшинд гүйцэтгэх боломж бүрдэж байна.</p> <p>Японы International Smart Aquaculture ХХК (ISAC) нь битүүмжлэгдсэн орчинд дахин ашиглах системийг ашиглан эх газарт далайн загас үржүүлэх зорилгоор 300 тонн усны багтаамжтай аквариум бүхий туршилтын</p>	40		

					<p>фермийг Монгол Улсад байгуулсан бөгөөд загасны халдварт өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх системийн дагуу ямар нэг тодорхой өвчний вирусгүй жараахайг тасалгаанд өвчний үүсгэвэр болох вирус нэвтэрхээс хамгаалан тэжээж, жилд 8 тонн загас үйлдвэрлэхээр төлөвлөж байна.</p> <p>Монгол зөгийн балыг Европын улс орнууд руу экспортлоход “Үлдэгдлийг хянах төлөвлөгөө”-ний дагуу “Монгол Улсын стандартчиллын тогтолцоог боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх нь” төслийн баг, төслийн зөвлөх, шинжээч, Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Шаамар сумын зөгийн аж ахуй эрхлэгч нартай уулзалт хийн, зөгийн аж ахуйтай газар дээр нь танилцан, “ЕХ-ы улсуудад зөгийн бал экспортлох нь” сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав. Уг сургалт, хэлэлцүүлэгт Сэлэнгэ аймгийн зөгийчид, төрийн болон ТББ-ын нийт 220 гаруй хүнийг хамруулав.</p> <p>2016-2017 онд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт болон орон нутгийг хөгжүүлэх сангийн зээлийн дэмжлэгтэйгээр дараах мал төхөөрөх, боловсруулах үйлдвэрийг байгуулж, ашиглалтанд оруулсан байна. Тухайлбал:</p> <ol style="list-style-type: none"> <li>1) Ховд аймгийн “Жаргалант шанд” ХХК нь өөрийн хөрөнгөөр хоногт 500 бог, 100 бод төхөөрөх хүчин чадалтай, 100 тн хөргүүртэй зоорь бүхий мал төхөөрөх, боловсруулах үйлдвэр,</li> <li>2) Орхон аймгийн “Жаргалант мах импекс” ХХК нь өөрийн хөрөнгөөр хоногт 100 бог, 20 бод төхөөрөх хүчин чадалтай, 200 тн хөргүүртэй зоорь бүхий мал төхөөрөх, боловсруулах үйлдвэр,</li> <li>3) Баянхонгор аймгийн “Мах март” ХХК нь өөрийн хөрөнгөөр Баянхонгор суманд хоногт 500 бог, 50 бод төхөөрөх хүчин чадалтай, 250 тн агуулах зоорь бүхий мах бэлтгэх, боловсруулах үйлдвэр,</li> <li>4) Говь-Алтай аймагт “Алтайн сүрлэг” ХХК өөрийн хөрөнгө болоод Орон нутгийг хөгжүүлэх сангаас 60.0 сая.төг-ийн зээл авч хоногт Есөнбулаг суманд 100 бод, 250 бог төхөөрөх хүчин чадалтай, 100 тн хөргүүртэй зоорь бүхий “Түмэн уул” мах бэлтгэх боловсруулах үйлдвэр,</li> <li>5) Төв аймгийн Баяндэлгэр суманд “Баяндэлгэр хүнс” ХХК Сингапур Улсын хөрөнгө оруулалтаар хоногт 100 бог, 50 бод төхөөрөх хүчин чадалтай, 20 тн хөргүүртэй</li> </ol>			
--	--	--	--	--	--	--	--	--



						зоорь бүхий мах бэлтгэх, ангилж вакуумжуулан савлах, үйлдвэрийг б) Улаанбаатар хотын “Саян уул” ХХК нь өөрийн хөрөнгөөр СХД-ийн Эмээлтэд 300 бог, 100 бод төхөөрөх хүчин чадалтай, 1000 тн агуулах зоорь бүхий мах бэлтгэх, боловсруулах үйлдвэрийг тус тус ашиглалтанд оруулсан байна.			
13	2.25. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтийг сайжруулах, дэвшилтэт техник, технологийн шинэчлэлийг хийх, инновацийг нэвтрүүлэх, түүнчлэн “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.	1	“Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын эхний үе шатны төлөвлөгөө, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хоёр дахь үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, хэрэгжүүлэх  /МААБХЗГ/	2016-2020	“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хоёр дахь үе шатны үйл ажиллагааны болон “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын төлөвлөгөөний хэрэгжилтийг 20 хувьд хүргэх	- “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2016 онд хэрэгжүүлсэн ажлын тайланг холбогдох газар, байгуулагуудаас хүлээн авч нэгтгэн мониторинг хийлгүүлэн ЗГХЭГ-т хүргүүлж байна. - “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг улсын хэмжээнд зохицуулах, удирдан зохион байгуулах үндэсний хороог шинэчлэн байгуулахаар санал авч шинээр байгуулан 4 дүгээр сарын эхний 10 хоногт багтаан хуралдуулж 2016 оны тайлан, 2017 оны төлөвлөгөөг батлуулахаар төлөвлөн ажиллаж байна. - Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн хэвийн байдлыг хангах хаваржилт, мал төллөлтийн бэлтгэл хангуулах МАА-н графикт ажлыг мөрдлөг болгон ажиллах талаар аймгуудын Засаг дарга нарт зөвлөмж хүргүүлсэн ба улсын хэмжээнд мал хаваржилт, төллөлтийг зохион байгуулах нэгдсэн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	40		
		2	Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл болон малын тэжээл, хадлан бэлтгэлд техник, технологийн шинэчлэл, инновацийг нэвтрүүлэх, лизингийн үйлчилгээг хөгжүүлэх  /МААБХЗГ/	2016-2020	-МАА-н үйлдвэрлэлийн техникийн шинэчлэлийг 5-аас доошгүй хувиар,  -Дэвшилтэт технологи, иннова-цийн бүтээгдэхүүн нэвтрүүлэлтийг 3	-Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх Малын үүлдэр угсаа чанарыг сайжруулах, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх төсөл, Малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх төслийг тус тус бэлтгэж холбогдох газруудад хүргүүлэв. -Эрчимжсэн мал аж ахуйн тэжээлийн үйлдвэрийг бүсчилэн байгуулах зорилгоор улсын хэмжээнд ажиллаж байгаа болон ажиллахгүй байгаа тэжээлийн үйлдвэрүүдийн судалгааг авч нэгтгэж, хаана ямар хүчин чадалтай тэжээлийн үйлдвэр байгуулах талаар судалгаа хийх ажлыг зохион байгуулж байна. -Малчин өрх, фермер, мал эмнэлэг, үржлийн анхан шатны нэгжид техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх төсөл сонгон шалгаруулж, хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулахаар ажлын хэсэг байгуулагдан холбогдох баримт бичгийг	0		

					хувиар нэмэгдүүлэх	бэлтгэн ажиллаж байна.			
14	2.26. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол малчин”, “Малжуулах” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	1	“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх хоёр дахь үе шатны хэрэгжилтийг зохион байгуулах /МААБХЗГ/	2017-2020	“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх хоёр дахь үе шатны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах, хэрэгжилтийг 30 хувьд хүргэх	- Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хоёр дахь үе шатны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж холбогдох байгууллага, газартай хамтран тооцоо, судалгааг хийж санал авах ажил хийгдэж байна. - Залуу малчин төслийн анотаци, зураглал хийж туршилтаар аймаг бүрээс 2-оос доошгүй сум сонгож ХНХЯамны малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөртэй уяалдуулан хэрэгжүүлэхээр ажиллаж байна.	0		
	2	Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд үзүүлэх бизнес инкубацийн үйлчилгээг боловсронгуй болгох, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжин хөгжүүлэх /ЖДҮХБХЗГ/	2017-2020	Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч-дэд үзүүлэх бизнес инкуба-цийн үйлчилгээ шинэ түвшинд хүрч, шинээр гарааны бизнес эрхлэгчид болон инкуба-циас үйлчилгээ авсан иргэн, ААН-ийн тоо нэмэгдэх	АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг(USAID), Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран жижиг, дунд бизнесүүдийг санхүүгийн хувьд илүү бат бөх, тогтвортой үйл ажиллагаатай болоход шаардлагатай санхүүжилтийг банк, санхүүгийн байгууллагаас олж авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй REACH төсөлтэй хамтран 2016-10-26-нд “Жижиг, дунд бизнесүүдийн санхүүжилтийг дэмжих нь” сэдэвт форумыг зохион байгуулав. Ерөнхийлөгчийн Тамгын газар, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Монгол банктай хамтран иргэдийн санхүүгийн боловсролыг дэмжих чиглэлээр уулзалт хэлэлцүүлгийг Төрийн ордны Иргэний танхимд 2017-02-23-ний өдөр зохион байгууллаа. Хэлэлцүүлгээс энэ чиглэлээр зохион байгуулж буй арга хэмжээг нэгдсэн зохион байгуулалтад оруулж хамтран ажиллах талаар санал нэгдлээ. ХХААХҮЯ, Reach төслийн нэгжтэй хамтран 2017.05.12 өдөр Эм, эмнэлгийн тоног төхөөрөмжийн чиглэлийн ААН-үүдэд зориулсан “Үйлдвэрлэгч, бэлтгэн нийлүүлэгчийг холбох тогтвортой санхүүжилт” В2В уулзалтыг зохион байгуулж мэдээллээр ханган ажиллалаа. Уулзалтанд эм,эмнэлгийн тоног төхөөрөмж импортлогч, үйлдвэрлэгч 150 орчим ААН иргэд	0			



					оролцлоо.				
43	2.55. Гадаад орны өндөр болон дэвшилтэт технологи бүхий үйлдвэрийг франчайзаар оруулж нутагшуулан, хөнгөн, жижиг дунд үйлдвэрийн салбарт “Хөгжлийн загвар” үйлдвэр байгуулахыг дэмжинэ.	1	Экспортын бүтээгдэхүүний өсөлтийг нэмэгдүүлэх “Хөгжлийн загвар” үйлдвэр байгуулахыг дэмжих  /Хөн.ҮБХЗГ, ЖДҮХБХЗГ/	2016-2020	Гадаад орны дэвшилтэт технологийн болон франчайз үйлдвэр-рийг судлан сонгох, үйлдвэрлэгчдийг холбох, бизнесийн цогц систем, тогтолцооны сургалт бүхий арга зүйн зөвлөгөөгөөр хангах, сурталч-лан дэлгэрүүлж загвар үйлдвэр-рийг бий болгоход дэмжлэг үзүүлэх	<p>- Япон, Итали зэрэг улс орны дэвшилтэт технологийн болон франчайз үйлдвэрийг судлан сонгох, үйлдвэрлэгчдийг холбох, сургалт явуулах чиглэлээр уулзалт, хэлэлцээ хийж байна.</p> <p>-Италийн нэхмэлийн тоног төхөөрөмж үйлдвэрлэгчдийн холбоо, Канадын малын гаралтай түүхий эдийг боловсруулах бага оврын төхөөрөмж үйлдвэрлэгч Минимилс тоног төхөөрөмж үйлдвэрлэгчдийн холбоодтой санал солилцож, МННХ, МНБҮХ-дтой уулзуулж үйлдвэрлэгчдэд мэдээлэл хүргүүлэв.</p> <p>-Дотоодын жижиг, дунд үйлдвэр эрхлэгч, тоног төхөөрөмжийн компаниуд, сав, баглаа боодлын дизайныг сайжруулах, борлуулалтын сувгийг бий болгох бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулах зорилгоор 2017-02-22-ны өдөр Тэнгэр худалдааны төвд өдөрлөг зохион байгуулж уламжлалт аргаар ааруул, цагаан идээ үйлдвэрлэгч иргэн, худалдаачид, ааруул савлах тоног төхөөрөмж импортлогч, үйлдвэрлэгчдийн төлөөллүүд оролцлоо.</p> <p>-Цай үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгж, шинжлэх ухааны болон төрийн байгууллагуудын хамтарсан уулзалт-хэлэлцүүлгийг 2017-01-06-ны өдөр зохион байгуулав. Уг хэлэлцүүлэгт цайны үйлдвэрлэл эрхлэгч 20 гаруй төлөөлөл, Эрүүл мэндийн үндэсний төв, Байгаль орчин аялал жуулчлалын яам, Стандартчилал хэмжилзүйн газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, ШУА-ийн Ургамалын экологи, ургамлын нөөцийн лаборатори, Хими, химийн технологийн хүрээлэн, МУИС-ийн Ургамал био технологийн лаборатори, ХАА-н үйлдвэрлэлд ШУ-ны ололт нэвтрүүлэх төв, ШУТИС үйлдвэрлэл технологийн сургууль, ШХА-ийн Ногоон алт төсөл зэрэг байгууллагууд оролцов.</p> <p>- “Монголын нийгмийн энтрепренёруудын чуулган-2017”-ыг Хөгжлийн шийдэл ТББ-ын “Залуусын бизнесийг дэмжих санаачлага хөтөлбөр”-тэй хамтран 2017.05.24 өдөр зохион байгууллаа. Чуулганаар Монгол улсын хөгжилд нийгмийн энтрепренёруудын оролцоог нэмэгдүүлэх, туршлагыг түгээх, энтрепренёршип болон Менторингийн тухай ойлголтыг залууст дэлгэрүүлэх зорилготой юм. Чуулганд 100 гаруй бизнес эрхлэгч</p>	0		

						болон бизнесээ эхлүүлж буй залуус оролцлоо.			
44	2.56. Хөнгөн үйлдвэрийн чиглэлээр дэлхийн тэргүүлэх, дэвшилтэт техник, технологийн үзэсгэлэнг Монгол Улсад тогтмол зохион байгуулж, гадаад оронд зохион байгуулагдаж байгаа үйлдвэрийн тоног төхөөрөмж, бараа, бүтээгдэхүүний үзэсгэлэнд үйлдвэрлэгчдийг дэмжиж хамруулна.	1	Үйлдвэрлэл өндөр хөгжсөн улсын үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах, нэвтрүүлэх, үзэсгэлэн яармагт оролцоход дэмжлэг үзүүлэх  /ТЗУГ, Хөнгөн ҮБХҮГ, Хү.ҮБХЗГ, ГХАХ/	2017-2020	Парисын яармаг, Германы ногоон долоо хоног үзэсгэлэн яармагт үйлдвэрлэгчдийг хамруулан оролцуулж, худалдаа, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр хийхэд туслалцаа үзүүлэх	ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэн тэргүүтэй төлөөлөгчид 2017-01-18-22-ны өдрүүдэд Германы ногоон долоо хоног үзэсгэлэн яармагт оролцов.Үндэсний үйлдэрлэгчдээс “Бэст буйдан” ХХК болон Төв аймгийн мах боловсруулах үйлдвэрийн төлөөлөл дагалдан явсан. ӨМӨЗО-ны Ардын Засгийн газартай ХХААХҮЯ хамтран Монгол-Хятадын 2 дах удаагийн экспо арга хэмжээг 2017 оны 9 дүгээр сард зохион байгуулахаар санамж бичгийг байгуулаад байна. Санамж бичгийн дагуу ХХААХҮЯ-ны ТНБД Л.Баяртулгаар ахлуулсан Монголын талын ажлын хэсгийг байгуулан зохион байгуулалтын асуудлаар Хятадын талтай санал солилцов.. БНСУ-ын КОЙКА байгууллагын шугамаар зохион байгуулсан Нэхмэлийн үйлдвэрлэлийн хөгжлийн чиглэл сэдэвт 21 хоногийн сургалтад Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн 2 албан хаагчдыг хамруулах хүсэлт, анкетыг СЯ, БНСУ-ын Койка байгууллагад уламжилж, дэмжүүлэв.	0		
		2	"Монголд үйлдвэрлэв" үзэсгэлэн, худалдааг тогтмолжуулж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх /ЖДҮХБХЗГ, Хөн.ҮБХЗГ, Хү.ҮБХЗГ/	2017-2020	Монголд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлах үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	-Үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалтыг дэмжих зорилгоор 10 дахь жилдээ “Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэнг Тэнгэр худалдааны төвтэй хамтран зохион байгууллаа. Үзэсгэлэнгийн хүрээнд ХХААХҮ-ийн сайдын аймгийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний дагуу аймаг бүрт “Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэнг орон нутагт нэгэн зэрэг зохион байгуулсан. Цагаан сарын үзэсгэлэн худалдаанд давхардсан тоогоор 1450 иргэн, ААН оролцож нийт 4,0 дтэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн байна. -Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого, “Үндэсний үйлдвэрлэл”, Төрийн өмчийн ашиглалт, хяналтыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгуудын хүрээнд үндэсний үйлдвэрүүдийг дэмжих, хамтарч ажиллах нөхцлийг бүрдүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийг идэвхжүүлэх замаар эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг хамтдаа даван туулах, төрийн худалдан авалтад нийлүүлэх үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор “Төрийн өмчийн менежмент ба нийгмийн харилцаа – 2017”	40		

					<p>өдөрлөгийг 2017-04-07-08 өдрүүдэд Тэнгэр худалдааны төвд зохион байгууллаа.Өдөрлөгт үндэсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 150 аж ахуйн нэгж байгууллага бүтээгдэхүүнээ танилцуулан төрийн худалдан авалтанд санал болгох бүтээгдэхүүний жагсаалтыг хүргүүлэн төрийн өмчийн үйлдвэрийн газруудтай хамтран ажиллах талаар санал солилцсоны үр дүнд Нэхээсгүй эдлэл ХК нь Улаанбаатар Цахилгаан Түгээх Сүлжээ ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллалаа.Өдөрлөгийн үеэр ХХААХҮЯ-ны Жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас санаачлан 500 аж ахуйн нэгж байгууллага, иргэний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний танилцуулга бүхий “Монголд үйлдвэрлэв-2017” үндэсний бүтээгдэхүүний каталогийг бэлтгэн хэвлүүлж төрийн өмчит үйлдвэрийн 85, орон нутгийн өмчит 78 байгууллага, салбарын яамд, УИХ-ын гишүүд, агентлагуудын удирдлагууд болон худалдан авах үйл ажиллагаа хариуцсан газруудад хүргүүллээ.</p> <p>- “Жижиг Дунд Үйлдвэрийн Бүтээгдэхүүн, Үйлчилгээ, Технологи-2017 “ Олон улсын үзэсгэлэн 20 дахь жилдээ жижиг дунд үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг сурталчлах, экспортыг дэмжих, дэвшилтэт технологиудыг танилцуулах зорилгоор МҮХАҮТ-тай хамтран зохион байгуулав. Энэхүү үзэсгэлэнд Монголын үндэсний үйлдвэрлэгчидээс гадна ОХУ, Пакистан, БНАСАУ зэрэг орнуудаас оролцож бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчилав. Үзэсгэлэн 2017 оны 06 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулагдаж үзэсгэлэнгийн шилдгүүдийн шалгаруулалтын ажлын хэсэгт 2 өдөр ажиллав. Гранпри шагналд Дархан минж ХХК-ны Савхин хүрэм шалгарсан болХХААХҮЯамны жуух бичгээр Бажуна урлангийн Б.Батсүх шагнуулав.</p> <p>-Монголд үйлдвэрлэв-2017“ үндэсний үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүний нэгдсэн каталогт хөнгөн болон хүнсний 680 орчим үйлдвэрүүдийг хамруулан гаргаж, хэвлүүлэн ашиглаж байна. Уг эмхэтгэлд орсон дотоодын ААН, үйлдвэрлэгчдийг төрийн худалдан авалтаар дэмжих арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна.</p> <p>-Эх орны хүнсний бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлах, хэрэглэгчдэд үйлдвэрийн үнээр шууд худалдан авалт хийхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” уриан д дор “Намрын ногоон өдрүүд” нэгдсэн арга хэмжээг 2017 оны 9-р сард</p>		
--	--	--	--	--	--	--	--

					зохион байгуулах, хамтран ажиллах талаар санал боловсруулж, холбогдох газруудад хүргүүлэв. Мөн нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулахаар холбогдох бэлтгэл ажлыг хангаж байна.				
		3	Үндэсний уламжлалт болон орон нутгийн онцлог бүхий хоол, үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор дэмжих, таниулах, сурталчлах  /ХНХҮЗХ, Хү.ҮБХЗГ/	2017-2020	Үндэсний болон бүс нутгийн онцлогтой хоол, ундааны мэдээлэл, судалгааг хийж, нэгтгэх	Монгол үндэсний брэнд хоол, идээ ундааг хөгжүүлэх, суртчлах ажлыг идэвхижүүлэх зорилгоор 2016 оны 09-10 саруудад зохион байгуулагдсан Зүүн болон Говийн бүсийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын ажилтан, ажиллагсдад зориулсан сургалтад хичээл зааж, цаашид Монгол хоол, идээ ундааг орчин үетэй уялдуулан хөгжүүлэх арга замын талаар зөвлөгөө өгсөн. 2016 оны 11-р сарын 26-27-ны өдрүүдэд “Монгол улсын аварга тогооч-2016” шалгаруулах уралдааныг зохион байгуулж, орчин үеийн Монгол хоол, идээ ундаа Ази, Европ хоол, цэцэрлэг, эмнэлэг, сургуулийн хоол, нарийн боовны аварга тогоочийг шалгаруулж, орчин үеийн Монгол хоолны төрөлд Дархан-Уул аймгийн болон “ДЦС-ГҮ” ХХК-ын тогооч нар шилдгүүдээр тодорсон. 2016 оны 10-р сарын 05-ны өдөр ХХААХҮ-ийн салбарыг сурталчлах, Дэлхийн хүнсний өдөрт зориулсан өдөрлөгийн үеэр Монгол үндэсний хоол, идээ ундааг иргэд, хэрэглэгчдэд сурталчлах арга хэмжээг зохион байгуулж, эрүүл хоол, хүнс, хөнгөн үйлдвэрийн бараа бүтээгдэхүүнээр үйлчилсэн. Зүүн болон Төв, Хангайн бүсийн аймгуудын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын ажилтнуудад зориулан Сүхбаатар болон Дархан-Уул аймгуудад 2017 оны 4-5-р сард “Үндэсний болон орон нутгийн онцлогтой хоол, ундааг хөгжүүлэх нь” сэдвээр сургалт зохион байгуулж, салбарын бодлого, олон улсын хөгжлийн хандлага, ЭАЗД хэвшүүлэх, НАССР тогтолцооны талаар сургалтад хамрагдсан 420 гаруй хүнд хичээл зааж, мэдээлэл хүргэв.	0		
45	2.57. Хөнгөн үйлдвэрийн парк байгуулж, салбарын үйлдвэрүүдийн хамтын ажиллагааг дэмжин, кластерыг бүртгэлжүүлэн	1	Арьс, ширний үйлдвэрийн парк байгуулж, үйлдвэрүүдийг кластераар хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, загвар үйлдвэр	2016-2020		Арьс, ширний үйлдвэрийн цогцолборын дэд бүтцийг байгуулах үүрэг бүхий төслийн нэгж болох Нийслэлийн Засаг даргын харьяанд “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрлэлийн технологийн паркийн төслийн нэгж” орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг байгуулж, үйл ажилагаагаа эхлээд байна. Сонгосон байршилд байгаль орчинд ээлтэй, хаягдлаа бүрэн боловсруулах чадвартай Арьс ширний үйлдвэрийн цогцолбор байгуулахад усны нөөц, дэд бүтэц болон	70		

	<p>бодлогоор дэмжинэ.</p> <p>/Хөн.ҮБХЗГ/</p>		<p>байгуулахыг дэмжих</p>		<p>одоогийн арьс ширний үйлдвэрлэл эрхэлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийн эрх ашигт нийцүүлэхээр ажиллаж байна.</p> <p>-Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны 2016-11-23-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Засгийн газарт өгсөн чиглэлийн дагуу Арьс, ширний үйлдвэрүүдийг үйлдвэрийн шинэ бүс рүү шилжүүлэх арга хэмжээг 2017-12-31-ний дотор үе шаттайгаар зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх чиглэлээр ХХААХҮ-ийн Сайд, Нийслэлийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээнд тусган ажиллаж байна.</p> <p>-Нийслэлийн ЗДТГ-аас Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн I ээлжийн дэд бүтэц болох Цэвэрлэх байгууламж, Ажлын даалгавар боловсруулж, Нийслэлийн Хот байгуулалт, ерөнхий төлөвлөгөөний газраар 2015 онд батлуулсан. Үүний дагуу Европын сэргээн босголт хөгжлийн банктай Нийслэлийн Засаг дарга 2016 онд санамж бичиг байгуулсан.</p> <p>-Ундны усан хангамж, Технологийн усан хангамж, Парк доторх инженерийн шугам сүлжээ, Авто замын Зураг төслийг нийслэлийн төсвийн хөрөнгөөс 1,5 тэрбум төгрөгөөр гүйцэтгүүлж холбогдох байгууллагуудаар батлуулж хүлээн авсан.</p> <p>-Дээрхи үйлдвэрийн бүсийг үйлдвэрлэл технологийн парк, кластерийн хэлбэрээр зохион байгуулахаар төслийн бэлтгэл ажлыг гүйцэтгээд байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. “Аж үйлдвэрлийн парк”-ийн техник эдийн засгийн үндэслэл,</li> <li>2. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол,</li> <li>3. Үерийн байгууламжийн ажлын зураг төсөл,</li> <li>4. Цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл,</li> <li>5. Технологийн усан хангамжийн ажлын зураг төсөл,</li> <li>6. Ундны усан хангамжийн ажлын зураг төсөл,</li> <li>7. Паркийн техник технологийн түвшний үнэлгээ,</li> <li>8. паркийн цэвэрлэх байгууламжийн судалгаа зэрэг баримт бичгүүдийг боловсруулж, эрх бүхий байгууллагуудаар баталгаажуулсан.</li> </ol> <p>9.Бүтээн байгуулалтын хувьд барилга угсралтын үеийн цахилгаан хангамжийн эх үүсвэрийг байгуулаад байна “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн ҮТП” ОНӨТҮГ-аас үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар ирүүлсэн хүсэлт, материалыг</p>		
--	--	--	---------------------------	--	---	--	--

					судалж, буцааж дахин тооцоо судалгааг нягталж ирүүлсэнийг ЗГ-ын 2017-06-20 - ны хуралдаанаар хэлэлцүүлж, УТП-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай 178 дугаар тогтоол батлуулсан.				
		2	Арьс, ширний үйлдвэрийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалт бий болгох болон хаягдал усыг цэвэршүүлэх, ариутгах, дахин ашиглах орчин үеийн дэвшилтэт технологитой цэвэрлэх байгууламжийг байгуулах ажлыг зохион байгуулах	2017-2018	ТЭЗҮ-ийг хийлгэх	<p>“Арьс ширний үйлдвэрүүдийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх” төслийн саналыг ЗГ-ын хуралдаанаар 2015-11-23-ны өдөр хэлэлцүүлж, 459 дүгээр тогтоолоор батлуулсан.Энэхүү тогтоолын дагуу “Арьс ширний үйлдвэрүүдийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх” төслийн үндэслэл, танилцуулгыг БНСУ-ын ЭКСИМ банкны Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн фондын холбогдох маягтын дагуу бэлтгэж, Монгол улсын Сангийн яамны Зээл тусламжийн газраар дамжуулан хүргүүлсэн.</p> <p>Монгол, БНСУ-ын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд БНСУ-ын ЭКСИМ банкны төлөөлөгчид 2016-02-18-ны өдөр Улаанбаатар хотод Сангийн яаман дээр ирж ажиллахад, “Арьс ширний үйлдвэрүүдийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх”төслийн талаар Аж үйлдвэрийн яамнаас танилцуулга хийсэн.</p> <p>Төслийн ТЭЗҮ-ийг БНСУ-ын ЭКСИМ банкны Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сангаас олгодог техникийн туслалцааны хүрээнд боловсруулж өгөх боломжтойгоо илэрхийлээд байгаа юм.</p> <p>“Урьдчилсан цэвэрлэх байгууламжийг шинэчлэх” төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах талаар Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сангийн техникийн туслалцааг авах хүсэлтийг Монгол улсын Сангийн яамаар дамжуулан БНСУ-ын Сангийн яаманд уламжлах шаардлагатайг үндэслэн Аж үйлдвэрийн яамны 2016-07-20-ны өдөр албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Нийслэлийн засаг даргын тамгын газрын техникийн саналыг албан бичгээр авч, ХХААХҮЯ-наас 2016-10-12-ны 01/707 албан бичгээр Сангийн яамд дахин хүргүүлээд байна.</p>	0		
46	2.58. Хөдөө аж ахуйн биржээр арилжаалах бараа, түүхий эдийн нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, үйл ажиллагааг	1	Хөдөө аж ахуй болон үйлдвэрлэл, үйлчилгээний хоршоодын бэлтгэсэн малын гаралтай түүхий эдийг хөдөө аж	2017-2020	Хоршоо-дыг биржийн арил-жаанд оролцох болом-жоор хангах	Хоршоо хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийн хүрээнд түүхий эдийн тогтолцоонд хоршоодыг оролцуулах зорилгоор үндэсний хэмжээнд 4223 хоршоодод үнэлгээ хийх тендерийн хороог ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А-178 тоот тушаалаар байгуулан зөвлөх үйлчилгээний тендер зарласан.	40		
					-Хоршоо нь малчдын мал, түүхий эдийг цуглуулж анхан				

	<p>боловсронгуй болгоно.</p> <p>/БТГ/</p>	<p>ахуйн биржээр арилжих ажлыг эрчимжүүлэх</p>			<p>шатны тордолт хийн биржийн стандарт, эрүүл ахуйд нийцүүлэн бэлтгэж, биржтэй цахим хэлбэрээр зайнаас шууд холбогдох ба бирж дээр бараа, түүхий эдээ борлуулах захиалгыг биржийн арилжааны системээр дамжуулан гүйцэтгэх боломжтой бөгөөд биржийн итгэмжлэгдсэн агуулахад бараа, түүхий эдээ хадгалж, бүртгэл хөтлөх юм.</p> <p>Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК, Хэнтий, Сүхбаатар аймгуудын Засаг даргын Тамгын газартай хамтран 2017-03-24,25-ны өдрүүдэд Сүхбаатар аймгийн Баяндэлгэр суманд, 2017-03-26-27-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Чингис хотод, 2017-03-28-ны өдөр Хэнтий аймгийн Өмнөдэлгэр суманд боловсруулаагүй ноолуурын дуудлага худалдааг зохион байгуулж ноолуурын дуудлага худалдаанд малчид, үйлдвэр болон бизнес эрхлэгчид, хоршоодыг оролцуулав.</p> <p>Хэнтий, Сүхбаатар, Хөвсгөл, Баянхонгор аймгуудад “Хөдөө аж ахуйн бирж” ХХК болон Аймгуудын Засаг даргын Тамгын газартай хамтран 2017 оны боловсруулаагүй ноолуурын дуудлага худалдааг амжилттай зохион байгууллаа.</p> <p>Дуудлага худалдаагаар ноолуурын зах зээлийн жишиг үнэ харьцангуй өндөр тогтож, малчид, хоршоо биржийн арилжаанд шууд оролцох эхлэл тавигдсан. Малчдыг ноолуурын эцсийн худалдан авагчтай холбох ажлыг амжилттай зохион байгуулснаар 4 удаагийн дуудлага худалдаагаар нийт 12,7 тонн ноолуурын арилжаа явагдлаа.</p>			
		<p>2</p> <p>Хөдөө аж ахуйн биржийн системийг онлайн горимд шилжүүлэн хөгжүүлж, олон улсын шаардлагад нийцсэн технологийн шинэчлэл хийх</p>	<p>2017-2020</p>	<p>Тоног төхөөрөмж суурилуулах ажил эхлэх</p>	<p>Улсын Их хурлын 2015 оны 70 дугаар тогтоол, Засгийн газрын 2015 оны 330 дугаар тогтоолоор “Хөдөө аж ахуйн бирж” ХХК дахь төрийн эзэмшлийг 34 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гаргах замаар хөрөнгө оруулалт босгож, компанид технологийн шинэчлэл хийхийг даалгасан.</p> <p>Энэ ажлын хүрээнд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас ажлын хэсэг байгуулан хувьчлалын ажлыг зохион байгуулсан.</p> <p>“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-иас гаргасан нэмэлт хувьцааг “Эй Эф Жи капитал менежмент” ХХК, “АФГ санхүүгийн групп ХХК, “Глобал инвест фонд” ХХК, “Альянс финанс групп ББСБ” ХХК, “АФГ трейдинг” ХХК тус тус худалдан авсан боловч үлдэгдэл төлбөрийг хийгээгүй.</p>	<p>0</p>		

						Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017-04-25-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр “Хөдөө аж ахуйн бирж” ХХК –ийн хувьцаа худалдан авсан хуулийн этгээдийн гэрээнд өөрчлөлт оруулж 2017-05-31-ний өдрийг хүртэл сунгах, уг хугацаанд төлбөрийг барагдуулаагүй бол гэрээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд цуцлахаар шийдвэрлэсэн. Худалдан авагч нь хувьцааны үнийг хугацаандаа төлөөгүй тул гэрээг цуцалсан. Энэхүү гэрээ цуцалсантай холбогдуулан компанийн хувьчлалын талаар дахин санал боловсруулахаар ажиллаж байна.			
Тэргүүлэх зорилт №2.4. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, байгаль орчин, хүний эрүүл мэндийн шаардлагад нийцсэн барилгын үйлдвэрлэлийг дэмжиж, аюулгүй, хүртээмжтэй орон сууцаар хангах төрийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлнэ.									
2.92. Цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн ус болон хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлнэ.	2	Хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах чиглэлээр судалгаа хийх	2016 - 2018			Хяналтад нэмж авах	ҮБгүй		
Тэргүүлэх зорилт №3.1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг боловсруулж, хүн амыг аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчилгээ үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх эдийн засгийн тооцооллыг бий болгож, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлнэ. Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, дадал, хандлагад төлөвшүүлж нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн тусламж үйлчилгээг эрс сайжруулах, Халдварт бус өвчнөөс сэргийлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлого төлөвлөлтөд урт болон дунд хугацааны хөтөлбөр боловсруулж, чанар хүртээмжийг дээшлүүлнэ. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийг хангаж, нийгмийн хамгааллыг сайжруулна. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанартай уялдсан эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгоно.									
3.1.7. Эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулж хэрэгжүүлэн эх, нялхсын эндэгдлийг бууруулна.	2	Нялх, балчир хүүхдийн хоол, ундны бүтээгдэхүүний тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх	2017 - 2018			Хяналтад нэмж авах	ҮБгүй		



Тэргүүлэх зорилт №3.2.2. Шинжлэх ухааны удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгож, үр дүнд суурилсан санхүүжилтийн системийг нэвтрүүлж, мэдлэгт суурилсан инноваци, технологи, үйлдвэрлэлийг хөгжүүлж, шинжлэх ухааны үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ.									
47	3.2.36. Салбарын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх өндөр технологийн судалгаа ба хөгжил, инновацийн болон зөвлөх, нэвтрүүлэх үйлчилгээний үйл ажиллагааны суурь бүтцийг хөгжүүлэх, эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ.  /БТГ/	3	Судалгаа, хөгжлийн инкубатор төв, загвар аж ахуй, агро парк байгуулахад бодлогоор дэмжлэг үзүүлэх	2017-2020	10-15 загвар аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэх	Хугацаа болоогүй.	ҮБгүй		
		4	Зөвлөх нэвтрүүлэх үйлчилгээний хуулийн төслийг боловсруулж, батлуулах	2017-2020	Хууль боловсруулах суурь судалгаанууд хийгдэх	-“Хөдөө аж ахуйн зөвлөх нэвтрүүлэх үйлчилгээний тухай” хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий “Ажлын хэсэг байгуулах тухай” Сайдын 2016 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А-59 дүгээр тушаал батлагдсан байна. -“Инноваци-боловсрол хөдөө аж ахуйн салбарт” Үндэсний чуулганыг 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Төрийн ордны Сүхбаатар танхимд зохион байгуулж, чуулганаар “Хөдөө аж ахуйн зөвлөх нэвтрүүлэх үйлчилгээний тухай” хуулийн үзэл баримтлалын төсөлд тусгах санал зөвлөмжийн талаар хэлэлцэж зөвлөмж гарав. -“Хөдөө аж ахуйн зөвлөх нэвтрүүлэх үйлчилгээний тухай” хуулийн төсөл, хуулийн үзэл баримтлалын төсөл боловсруулах ажлын хэсгийн хурлыг 2 удаа зохион байгуулж хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хууль боловсруулах суурь судалгаануудыг хийж байна.	40		
48	3.2.37. Нээлттэй лабораторид суурилсан био, нанотехнологийг хөгжүүлж, оюуны багтаамж өндөртэй, экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлнэ.	3	Инновацийн зуучлал, мэдээлэл, маркетингийн тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр үндэсний болон олон улсын чуулган, зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, тодорхой шийдэл, үр дүнд хүрэх	2017-2020	Салбарын судалгаа ба хөгжлийн чиглэлээр олон улсын чуулган 1, салбарын хэмжээний зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг 2-оос доошгүй удаа зохион	Салбарын судалгаа ба хөгжлийн чиглэлээр олон улсын чуулган зохион байгуулах үүрэг бүхий “Ажлын хэсэг байгуулах” тухай Сайдын 2017 оны А-46 дугаар тушаалыг батлуулав. Ажлын хэсгийн хурлыг 2 удаа зохион байгуулав.	0		

	/БТГ/				байгуулах				
		4	Био, нано технологийг хөгжүүлж оюуны багтаамж, экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн инновацийн төслүүдийг хэрэгжүүлж, гарааны компани байгуулахад дэмжлэг үзүүлэх	2017-2020	5 инновацийн төсөл, 2-3 гарааны компани байгуулахад дэмжлэг үзүүлэх	Салбарт хэрэгжүүлэх шаардлагатай инновацийн 5 төслийн саналыг нэгтгэн БСШУСЯ-д хүргүүлэв.	0		
Тэргүүлэх зорилт №4.1. Байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх, байгалийн нөөц баялгийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, зохистой ашиглах, нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэн, байгаль орчинд нийцтэй, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, нийгмийн тогтвортой хөгжлийн үндэс болгоно. Аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг бүс нутгийн хэмжээнд дээшлүүлж, эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.									
	4.1.4. Ой, түүний дагалт баялаг, байгалийн бусад нөөц баялгийн ашиглалтын нөөцийг бий болгож, зохистой ашиглах, эко цэвэр түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	1	Ойг доройтлоос хамгаалж, ойн төлөв байдлыг сайжруулах, ойн замын сүлжээг өргөжүүлж, ойн нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах	2016 - 2020		Хяналтад нэмж авах	ҮБгүй		
	4.1.6. Хот, суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.	3	Хог хаягдлыг дахин боловсруулж, эрчим хүч, түүхий эд үйлдвэрлэх эко цогцолбор байгуулах	2017 - 2020		Хяналтад нэмж авах	ҮБгүй		
	4.2.8. Байгаль орчинг хамгаалах,	2	Генетик нөөц, түүнтэй холбоотой	2016 - 2020		Хяналтад нэмж авах	ҮБгүй		

	байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, ашиглалтын үр өгөөжийг сайжруулна.		уламжлалт мэдлэгийн талаарх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх, үндэсний чадавхийг бэхжүүлэх						
	4.3.3. Гамшгаас хамгаалах эрх зүйн орчин, менежментийн тогтолцоог боловсронгуй болгож, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, эртнээс сэрэмжлүүлэх үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, бүх нийтийн оролцоог сайжруулан, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлнэ.	8	Цаг агаарын гэнэтийн аюулт үзэгдлээс сэрэмжлүүлэх орон нутгийн дэд тогтолцоог дэмжин хөгжүүлэх (говь, хээрийн бүсийн аймгуудад аюулаас сэрэмжлүүлэн анхааруулах 16 цогцолбор байгуулах)	2017 - 2020		Хяналтад нэмж авах	ҮБгүй		
	4.3.3. Гамшгаас хамгаалах эрх зүйн орчин, менежментийн тогтолцоог боловсронгуй болгож, гамшгаас урьдчилан сэргийлэх,	9	Хөдөө орон нутагт уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, байгалийн гамшгийн эрсдэлийг даван туулах чадавхийг бэхжүүлж, амьжиргааг	2016 - 2020		Хяналтад нэмж авах	ҮБгүй		

<p>гамшгийн эрсдэлийг бууруулах, эртнээс сэрэмжлүүлэх үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, бүх нийтийн оролцоог сайжруулан, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлнэ.</p>		<p>сайжруулахад чиглэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх</p>						
<p>Тэргүүлэх зорилт №5.4. Чанд сахилга бат, дэг журамд суурилсан хүнлэг, иргэндээ ээлтэй, улсдаа түшигтэй, хууль хэлбэрэлтгүй мөрдөгдсөн хуулийн байгууллагыг бэхжүүлэх зарчмыг баримтална.</p>								
<p>5.4.10. Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд бүрэн шилжүүлэх, цагдан хорих байрны нөхцөлийг хүний жам ёсны эрхэд нийцүүлэх, ял эдлүүлэх ажиллагаанд цахим болон теле хяналтын системийг нэвтрүүлэх, ялтныг хөдөлмөрт бүрэн хамруулах, иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн зарим ажиллагааг онлайн хэлбэрт шилжүүлэх замаар шүүхийн шийдвэр</p>	<p>10</p>	<p>Шүүхийн шийдвэрийг биелүүлэх байгууллагаас эрчимжсэн мал аж ахуй болон газар тариалангийн аж ахуйг үе шаттай хөгжүүлэх</p>	<p>2017 - 2020</p>		<p>Хяналтад нэмж авах</p>	<p>ҮБгүй</p>		

	гүйцэтгэх ажиллагааг шинэтгэнэ.								
Тэргүүлэх зорилт №5.6. Монгол Улс энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого хэрэгжүүлж, гадаад бодлогын нэгдмэл байдал, залгамж чанарыг хадгалж, дэлхийн улсуудтай найрсаг харилцаа, улс төр, худалдаа, эдийн засаг, соёлын болон бусад салбарын хамтын ажиллагааг хөгжүүлж, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлж, бүс нутгийн хамтын ажиллагаанд оновчтой оролцож, хилийн чанадад Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжийн эрх ашгийг тууштай хамгаалж, иргэд гадаадад зорчих нөхцөлийг улам сайжруулж, эх орноо гадаадад сурталчилан таниулах ажлыг эрчимжүүлнэ.									
	5.6.8. Гадаадын зах зээлд экспортлох боломжтой тэргүүлэх ач холбогдол бүхий бараа бүтээгдэхүүний судалгаа, маркетингийг төрөөс дэмжих “Монгол экспорт” хөтөлбөрийг хэрэгжүүлж, Монгол-Экспо үзэсгэлэн яармаг арга хэмжээг зохион байгуулан, гадаад зах зээлд гарах нөхцөлийг сайжруулж, үндэсний аж ахуйн нэгж гадаадад хөрөнгө оруулах, дэлхийн санхүү, хөрөнгийн зах зээлд нэвтрэх таатай нөхцөлийг бүрдүүлнэ.	3	Хөдөө аж ахуйг хөгжүүлэх, түүний дотор махны экспортыг нэмэгдүүлэх талаар мах экспортлогч орнуудтай хамтран ажиллах, тэдгээрээс туршлага судлах, холбогдох гэрээ хэлэлцээр байгуулах	2016 - 2020		Хяналтад нэмж авах	ҮБгүй		
	5.6.12. “Зөгийн үүр” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, гадаадад сурч, ажиллаж өндөр мэдлэг, боловсрол,	7	Гадаадад эзэмшсэн мэдлэг, боловсрол, ур чадвар, туршлагаа ашиглан эх орондоо хөдөлмөр эрхлэх, жижиг, дунд болон	2016 - 2020		Хяналтад нэмж авах	ҮБгүй		

	технологи, ур чадвар эзэмшсэн залуучуудыг эх орондоо тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлнэ.		бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх боломжийг нэмэгдүүлэх						
<b>ЗУРГАА. АЙМАГ, ОРОН НУТГИЙН ТАЛААР ТУСГАЙЛАН ОРУУЛАХ ЗААЛТУУД</b>									
<b>6.1. Архангай аймаг</b>									
49	6. Өргөн хэрэглээний 8 нэрийн бараа бүтээгдэхүүнийг аймагтаа үйлдвэрлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ. /Хүнсний ҮБХЗГ/	1	Өргөн хэрэглээний 8 нэрийн бараа бүтээгдэхүүнийг аймагтаа үйлдвэрлэх хөтөлбөр хэрэгжүүлэх	2016-2020	Үйлдвэр баригдах	Архангай аймгийн Эрдэнэбулган суманд Дэлхийн банкны 500 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай, 100-150тн багтаамжтай агуулах бүхий мал нядлах, хадгалах үйлдвэр ашиглалтанд ороход бэлэн болоод байна. Хангай, Тариат, Чулуут, Ихтамир, Цэнхэр, Эрдэнэмандал сумдад хуурай сүүний үйлдвэр байгуулах ажлын хүрээнд үйлдвэрийн байрны асуудал болон үйлдвэрийн ажиллах хүчинг сонгон шалгаруулах шатанд явагдаж байна. Аймгийн 19 сумыг түүхий эдийн нөөцөнд тулгуурлан бүсчилэн хөгжүүлэхээр төлөвлөж байна. 1. Төвийн бүс болох Ихтамир, Эрдэнэбулган, Булган, Цэнхэр суманд хүнсний ногоо боловсруулан савлах үйлдвэр, хуурай сүүний үйлдвэр, махны боловсруулах үйлдвэр 2. Баруун бүс болох Цахир, Хангай, Тариат, Өндөр-Улаан, Чулуут суманд цагаан идээний үйлдвэр, жимс жимсгэнэ боловсруулах үйлдвэр 3. Хойд бүс болох Жаргалант, Цэцэрлэг, Эрдэнэмандал, Хайрхан суманд цагаан идээний үйлдвэр, жимс жимсгэний үйлдвэр 4. Зүүн бүс болох Өлзийт, Өгийнуур, Хашаат, Хотонт, Төвшрүүлэх, Батцэнгэл суманд мах сүүний чиглэлийн фермерийн аж ахуй байгуулах, чацаргана боловсруулах, ундаа жүүсний үйлдвэр, гурил тэжээлийн үйлдвэрийг байгуулах, өргөтгөх зэргээр	ҮБгүй		
	7. Газар тариалангийн бүс нутгийг түшиглэн малын тэжээлийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	1	Газар тариалангийн бүс нутгийг түшиглэн малын тэжээлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх /Эрдэнэбулган, Төвшрүүлэх,	2016-2020	Аймгийн хэмжээнд дотоодын хэрэгцээнй 30 хувийг хангах	Эхний ээлжинд арьс ширэн түүхий эдийг тордох, чанар хамгаалалт хийх цехийг орон нутагт байгуулахаар судалгаа хийж байна. Орон нутагт үйлдвэр байгуулахад түүхий эд, дэд бүтцийн нөөц, ажиллах хүчний боломж, зах зээл зэрэг хүчин зүйлүүдтэй уялдуулахаар нөхцөл байдлыг нь судалж байна.	ХБ		

			Хайрхан, Өлзийт сумдад тэжээлийн үйлдвэр						
6.2. Баян-Өлгий аймаг									
50	4. Өлгий хот болон Дэлүүн, Булган, Ногооннуур, Улаанхус, Цэнгэл, Толбо зэрэг томоохон сумдад арьс шир боловсруулах үйлдвэр байгуулна. /Хөн.ҮБХЗГ/	3	Үйлдвэр байгуулах, ашиглалтад оруулах, үр ашигтай үйл ажиллагаа явуулахад бодлогоор дэмжлэг үзүүлэх	2017-2020	Дэлүүн, Ногооннуур сумдад үйлдвэр барих	Эхний ээлжинд арьс ширэн түүхий эдийг тордох, чанар хамгаалалт хийх цехийг орон нутагт байгуулахаар судалгаа хийж байна. Орон нутагт үйлдвэр байгуулахад түүхий эд, дэд бүтцийн нөөц, ажиллах хүчний боломж, зах зээл зэрэг хүчин зүйлүүдтэй уялдуулахаар нөхцөл байдлыг нь судалж байна.	ҮБгүй		
6.3. Баянхонгор аймаг									
51	7. Ноос, ноолуур болон мал аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулна. /Хөн.ҮБХЗГ/	1	Үйлдвэрийг байгуулж ашиглалтад оруулах	2017-2020	Үйлдвэрийн ТЭЗҮ-ийг хийлгэх, барилгын ажлыг эхлүүлэх	Үйлдвэржилт 21:100 хөтөлбөрийн хүрээнд Бэлэн бүтээгдэхүүний үйлдвэртэй хоршин ажилладаг орон нутагт шилжин ажиллаж байгаа ноос угаах үйлдвэрийг хөгжүүлэхээр төлөвлөж байна.	ҮБгүй		
	8. Жил бүр 20-оос доошгүй инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргаж, 50-аас багагүй газарт усны хайгуулын ажил хийнэ. /МААБХЗГ/	1	Хайгуул хийсний үр дүнд инженерийн хийцтэй гүн өрмийн 80 худаг гаргах, хайгуулын ажлыг 200 цэгт хийх	2017-2020	Усны хайгуулын ажлыг 50 цэгт хийх, шинээр 20 инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргах	Улсын төсөвт тусгагдаагүй.	ҮБгүй		
6.4. Булган аймаг									
52	2. Булган аймгийн газар тариалан эрхлэгчдийг дэмжих зорилгоор Хутаг-Өндөр суманд 15000 тн багтаамжтай үр тариа хадгалах	1	Газар тариалан эрхлэгчдийг дэмжих зорилгоор Хутаг-Өндөр суманд 15000 тн багтаамжтай үр тариа хадгалах элеваторын	2017-2020	Тэшиг, Хутаг-Өндөр, Баян-Агт, Сайхан, Хөвсгөл аймгийн Тариалан	Улсын төсөвт тусгагдаагүй.	ҮБгүй		

	элеваторын барилгыг барих, аймгийн төв, Хутаг-Өндөр сумдад төмс, хүнсний ногоо хадгалах механикжсан зоорь барина. /ГТБХЗГ/		барилгыг барих		сумуудын үр тариаг хадгалах, нөөцлөх боломжтой болох				
		2	Аймгийн төв, Хутаг-Өндөр сумдад төмс, хүнсний ногоо хадгалах 5000 тн багтаамжтай механикжсан зоорь барих	2017-2020	Хүнсний ногооны хангамж нэмэгдэж, хүнсний баталгаат байдал сайжрах	Улсын төсөвт тусгагдаагүй.	ҮБгүй		
	3. Мах боловсруулах дунд зэргийн хүчин чадал бүхий үйлдвэрийг Булган, Дашинчилэн сумдад байгуулна. /Хү.ҮБХЗГ/	1	Мах боловсруулах дунд зэргийн хүчин чадал бүхий үйлдвэрийг Булган, Дашинчилэн сумдад байгуулах	2017-2020	Дашинчилэн суманд махны үйлдвэр байгуулах	-Булган суманд төсвийн хөрөнгөөр (УИХ-ын гишүүний хувиарлагдсан хөрөнгөөс 100.0 сая.төг-ийн санхүүжилтээр) барилга баригдаж, тоног төхөөрөмж суурилагдсан дунд зэргийн хүчин чадал бүхий махны үйлдвэрт Булган аймгийн “Бүрэн зуу” ХХК нь хувийн хөрөнгө оруулалт хийж, барилгыг гүйцээн барих саналыг аймгийн ХХААГ-т тавьсан байна. Саналын дагуу ХХААГ-аас зохицуулалтын ажлыг хийж байна. -Түүнчлэн Булган суманд дунд зэргийн хүчин чадалтай мал төхөөрөх үйлдвэр байгуулах талаар “Мерси Кор” ОУБ-тай хамтран ажиллаж, хөргүүртэй зоорь, махны нөөцийн талаарх судалгааг гаргаж хүргүүлсэн.	ҮБгүй		
6.7. Дархан-Уул аймаг									
53	3. Арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэрийг байгальд ээлтэй цогцолбор хэлбэрээр хөгжүүлнэ. ХөнбҮБХЗГ	1	Арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэрийг байгальд ээлтэй цогцолбор хэлбэрээр хөгжүүлэх	2017-2020	Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр дэд бүтцийн зураг төсөл боловсруулах	Улсын төсөвт тусгагдаагүй.	ҮБгүй		
6.11. Завхан аймаг									
54	3. Аймагтаа хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулахыг	1	Тэлмэн суманд хөдөө аж ахуйн үйлдвэрийн цогцолбор байгуулах ажлын	2017-2020	Суурьшлын бүсийн зураг төсөв боловсруулах	Улсын төсөвт тусгагдаагүй.	ҮБгүй		



	дэмжинэ. /Хөн.ҮБХЗГ/		хүрээнд суурьшлын бүсийн зураг төсвийг боловсруулах						
6.12. Орхон аймаг									
55	7. Зоорьтой хүнсний зах байгуулж, төмс, хүнсний ногооны хангамжийг эрс сайжруулна. /ГТБХЗГ/	1	Зоорьтой хүнсний зах байгуулж, төмс, хүнсний ногооны хангамжийг эрс сайжруулах	2016- 2020	Зураг төсвийн ажил хийгдэх	Улсын төсөвт тусгагдаагүй.	ҮБгүй		
6.15. Сүхбаатар аймаг									
56	1. Ноолуур, ноос угаах самнах, ээрэх зэрэг хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулахыг дэмжинэ. /Хөн.ҮБХЗГ/	1	Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах төв байгуулах	2017- 2020	Төвийн үйл ажиллагаа эхлэх	Үйлдвэржилт 21:100 хөтөлбөрийн хүрээнд Бэлэн бүтээгдэхүүний үйлдвэртэй хоршин ажилладаг орон нутагт шилжин ажиллаж байгаа ноос угаах үйлдвэрийг хөгжүүлэхээр төлөвлөж байна	ҮБгүй		
6.16. Сэлэнгэ аймаг									
57	3. Сум бүрт төмс хүнсний ногооны зоорь барьж, ногоог жилийн туршид хадгалах, борлуулах боломжийг бүрдүүлнэ. /ГТБХЗГ/	1	Сум бүрт төмс, хүнсний ногооны зоорь барих	2017- 2019	6 суманд барих	Улсын төсөвт тусгагдаагүй.	ҮБгүй		
		2	Улаанбаатар хотод Сэлэнгэ аймгийн ногоочдын төмс, хүнсний ногоо хадгалах нэгдсэн зоорь барих /1000 тн/	2017	Зураг төсөв, ТЭЗҮ-ийг боловсруула х	Улсын төсөвт тусгагдаагүй.	ҮБгүй		
6.17. Төв аймаг									
58	2. Малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь өргөжүүлэх аж ахуйн нэгж, иргэдийг дэмжинэ.	1	Малын тэжээлийн тариалалтын бүс нутгийг тогтоож, тэжээлийн ургамлын үрийн нөөцтэй болгох, малын тэжээлийн ургамлын	2017- 2020	Малын тэжээлийн үйлдвэр 2 суманд байгуулах	Улсын төсөвт тусгагдаагүй.	ҮБгүй		

	/МААБХЗГ/		тариалалтыг нэмэгдүүлж, эрчимжсэн аж ахуйн тэжээлийн хэрэгцээг хангах, малын тэжээлийн үйлдвэрийг 5-с доошгүй сумдад байгуулах						
6.18. Увс аймаг									
59	3. Малын гаралтай түүхий эд, жимс, жимсгэнэ, хүнсний ногоо боловсруулах жижиг, дунд үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	1	Дулааны аргаар мах боловсруулах үйлдвэр байгуулах  /Хү.ҮБХЗГ/	2018		Увс аймгийн Тариалан суманд “Хүмэн нэгдэл” ХХК-иас Австри улсын “BERTSCH LASKA” компаний тоног төхөөрөмж суурилуулан Европын Холбооны стандартын дагуу мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийг байгуулах барилгын ажлын нээлтийг 2017 оны 6-р сарын 11-ний өдөр хийлээ. Төслийн ерөнхий захиалагч “Хүмэн нэгдэл” ХХК бөгөөд 15 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалтаар барьж байгуулах юм. Тус үйлдвэр ашиглалтанд орсноор 1 ээлжиндээ 40-50 бод, 120-150 бог бэлтгэж жилдээ 1000 тн малын мах, 600 тн хагас болон бэлэн боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай юм. Малчидтай урьдчилан гэрээ байгуулж бэлтгэлд нийлүүлэх мал сүргийг им, тэмдэг, бар кодын систем ашиглан бүртгэлжүүлж, мэдээллийн сан байгуулж, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан хэрэглэгчдийг хүнсний эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсээр хангахаар зорьж байна. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ эхний ээлжинд дотоодын зах зээлд нийлүүлж, цаашид хүнсний аюулгүй байдлын НАССР, ISO тогтолцоог нэвтрүүлж баталгаажуулснаар ангилж савлан шинэ болон хөлдөөсөн мах, төрөл бүрийн хиа, махан бүтээгдэхүүн, махан нөөш, дотор махан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, улмаар бүтээгдэхүүнээ экспортлох боломжтой юм.	0		
		2	Сүүний үйлдвэр байгуулах /Хү.ҮБХЗГ/	2019		-Увс аймгийн засаг даргын 2016-2020 ондхэрэгжүүлэх “Манай увс” Үйл ажиллагааны хөтөлбөрт саналыг тусган ажиллаж байна.	0		
		3	Хүнсний ногоог вакуумжуулсан аргаар боловсруулах үйлдвэр байгуулах	2018		-Увс аймгийн засаг даргын 2016-2020 ондхэрэгжүүлэх “Манай-Увс” Үйл ажиллагааны хөтөлбөрт саналыг тусган ажиллаж байна.	0		

			/Хү.ҮБХЗГ/						
		4	Малын арьс шир, ноос боловсруулах үйлдвэр байгуулах /Хөн.ҮБХЗГ/	2018-2019		Улсын төсөвт тусгагдаагүй.		ҮБгүй	
		5	Чацарганыг кластержуулж хөгжүүлэх, боловсруулах үйлдвэрийн технологийг шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлэх /ГТБХЗГ/	2017-2018	Ажлын гүйцэтгэлийг 40 хувьд хүргэх	Увс аймгийн Тариалан суманд “Хүмэн нэгдэл” ХХК-иас Австри улсын “BERTSCH LASKA” компаний тоног төхөөрөмж суурилуулан Европын Холбооны стандартын дагуу мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийг байгуулах барилгын ажлын нээлтийг 2017 оны 6-р сарын 11-ний өдөр хийлээ. Төслийн ерөнхий захиалагч “Хүмэн нэгдэл” ХХК бөгөөд 15 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалтаар барьж байгуулах юм. Тус үйлдвэр ашиглалтанд орсноор 1 ээлжиндээ 40-50 бод, 120-150 бог бэлтгэж жилдээ 1000 тн малын мах, 600 тн хагас болон бэлэн боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай юм. Малчидтай урьдчилан гэрээ байгуулж бэлтгэлд нийлүүлэх мал сүргийг им, тэмдэг, бар кодын систем ашиглан бүртгэлжүүлж, мэдээллийн сан байгуулж, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан хэрэглэгчдийг хүнсний эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсээр хангахаар зорьж байна. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ эхний ээлжинд дотоодын зах зээлд нийлүүлж, цаашид хүнсний аюулгүй байдлын HACCP, ISO тогтолцоог нэвтрүүлж баталгаажуулснаар ангилж савлан шинэ болон хөлдөөсөн мах, төрөл бүрийн хиам, махан бүтээгдэхүүн, махан нөөш, дотор махан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, улмаар бүтээгдэхүүнээ экспортлох боломжтой юм.	40		
6.19. Ховд аймаг									
60	7. Малын гаралтай түүхий эд болон ноос ноолуур боловсруулах үйлдвэр байгуулна.  /Хөн.ҮБХЗГ/	7	Малын гаралтай түүхий эд болон ноос ноолуур боловсруулах үйлдвэр байгуулах	2017-2018	Зураг төсвийн дагуу тендер зарлаж, ажлын гүйцэтгэлийг 50 хувьд хүргэх	Үйлдвэржилт 21:100 хөтөлбөрийн хүрээнд Бэлэн бүтээгдэхүүний үйлдвэртэй хоршин ажилладаг орон нутагт шилжин ажиллаж байгаа ноос угаах үйлдвэрийг хөгжүүлэхээр төлөвлөж байна.		ҮБгүй	
61	9. Малын гаралтай түүхий эдийн боловсруулалтын цэвэрлэх байгууламж	9	Малын гаралтай түүхий эдийн боловсруулалтын цэвэрлэх байгууламж барих	2017	ХАА-н гаралтай түүхий эд боловсруулах	Улсын төсөвт тусгагдаагүй.		ҮБгүй	

	барина. /Хөн.ҮБХЗГ/				үйлдвэ-рийг ашиглал-тад хүлээн авах				
6.21. Хэнтий аймаг									
62	2. 21:100 хөтөлбөрийн хүрээнд арьс шир боловсруулах, ноос ноолуур угаах үйлдвэрийг барихыг дэмжинэ.  /Хөн.ҮБХЗГ/	1	Арьс, шир боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулах	2017- 2020	Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 25 хувьд хүрэх	Эхний ээлжинд арьс ширэн түүхий эдийг тордох, чанар хамгаалалт хийх цехийг орон нутагт байгуулахаар судалгаа хийж байна. Орон нутагт үйлдвэр байгуулахад түүхий эд, дэд бүтцийн нөөц, ажиллах хүчний боломж, зах зээл зэрэг хүчин зүйлүүдтэй уялдуулахаар нөхцөл байдлыг нь судалж байна. Хэнтий аймаг өнгөрсөн жилд байгуулагдсан гутлын үйлдвэрийн үйл ажиллагааг сэргээх чиглэлээр хувийн хэвшлийн эрх ашиг, бизнес төлөвлөгөөг сайжруулахаар төлөвлөн, судалж байна. Үйлдвэрижлт 21:100 хөтөлбөрийн хүрээнд Бэлэн бүтээгдэхүүний үйлдвэртэй хоршин ажилладаг орон нутагт шилжин ажиллаж байгаа ноос угаах үйлдвэрийг хөгжүүлэхээр төлөвлөж байна	ҮБгүй		

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ